

**ОЮУ ТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 3 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” 92 дугаар тогтоол баталсан. УИХ-ын дээрх тогтоолын дагуу Оюу толгойн ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах асуудлыг шийдвэрлэхийн тулд уг ордыг ашиглахаар гадаадын хөрөнгө оруулагч талтай байгуулсан холбогдох гэрээнүүдийг судлан, дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн үзсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүнээс өгсөн үүрэг, даалгаврын дагуу Зөвлөлийн Ажлын албанаас Оюу толгойн ордыг ашиглахаар гадаадын хөрөнгө оруулагчтай 2009 онд байгуулсан “Хувь нийлүүлэгчийн гэрээ”, 2011 онд байгуулсан “Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчийн гэрээ”-г судалж, дүн шинжилгээ хийж санал, дүгнэлт гаргасан болно.

Төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” компани 2009 болон 2011 оны ХНГ-г байгуулахдаа УИХ-аар хэлэлцүүлээгүй, танилцуулаагүй байна.

2009 болон 2011 оны Хувь нийлүүлэгчийн гэрээг харьцуулан судалсан бөгөөд энэхүү санал, дүгнэлтэд ХНГ-г 2009 оны ХНГ, 2011 оны ХНГ гэж тодотгон заасан болно. *(2009 онд байгуулсан Хувь нийлүүлэгчийн гэрээг 2011 онд дахин тодотгож нэмэлт, өөрчлөлт оруулсан заалтуудыг харьцуулж, энэхүү санал, дүгнэлтэд хавсаргав)*

2011 онд ХНГ-г дахин тодотгож нэмэлт, өөрчлөлт оруулснаар 2009 оны ХНГ-ний зүйл, заалтын дугаарлалт өөрчлөгдсөн бөгөөд энэхүү Санал, дүгнэлтэд өөрчлөгдсөн дугаараар нь тэмдэглэж дурдсан тул Гэрээний зүйл, заалтын дугаар 2009 оны ХНГ-ээс өөр болохыг тэмдэглэе. 2009 оны ХНГ-нд 2011 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, одоог хүртэл хүчинтэй байгаа хэдий ч 2009 оны гэрээний холбогдох заалтууд “Оюу толгой” төсөлтэй холбоотой ямар харилцааг, хэрхэн зохицуулж байсныг харуулахын тулд энэхүү дүгнэлтэд дурдсан болно.

Монгол Улсын Засгийн газраас Оюу толгойн ордтой холбоотой шаардлагатай бусад мэдээллийг бүрэн авч чадаагүй тул зөвхөн гэрээний заалтын хүрээнд санал, дүгнэлт гаргалаа. Зөвлөлийн Ажлын албанд байхгүй мэдээллээр зарим нөхцөл байдал өөрчлөгдсөн болохыг үгүйсгэхгүй.

**НЭГ. ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГЭРЭЭ (2009 он) БОЛОН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ ДАХИН ТОДОТГОСОН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГЭРЭЭ (2011 он)**

1.1 Анх 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Улаанбаатар хотод “Эрдэнэс МГЛ” ХХК (цаашид “ТӨК” гэх) болон “Айвенхоу Оюу Толгой” (БиВиАй) Лтд (цаашид “АйВиЭн” гэх), “Оюу Толгой Нидерланд БиВи” (цаашид “ОТН” гэх), “Айвенхоу Майнз Монголиа Инк” ХХК (цаашид “Компани” гэх) хооронд Хувь нийлүүлэгчийн гэрээ (цаашид “ХНГ” гэнэ) байгуулжээ. Энэ гэрээ нь “Нууц” зэрэглэлтэй. 2011 онд нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон ХНГ-ээр ил болсон.

1.2 Энэхүү ХНГ-ний 23.6-д “Талууд зөвхөн өөр гэрээ байгуулах замаар энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно” гэсний дагуу 2011 онд “Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон Хувь нийлүүлэгчийн гэрээ”-г (цаашид “2011 оны ХНГ” гэх) 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр байгуулжээ. Энэхүү гэрээг нууцлаагүй.

1.3 2011 онд дахин тодотгож нэмэлт, өөрчлөлт оруулсан ХНГ-ээр “Айвенхоу Майнз Инк” ХХК нь “Оюу толгой” ХХК компани болж нэрээ өөрчилжээ.

Хувь нийлүүлэгчийн гэрээ байгуулсан нэг оролцогч тал болох “Айвенхоу Оюу Толгой” (БиВиАй) Лтд нь оффшор бүс болох Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй компани байх бол нөгөө нэг тал болох “Оюу Толгой Нидерланд БиВи” компани нь Нидерланд Улсад бүртгэлтэй компани байна. “Оюу толгой” төслийг ашиглах гадаадын хамтрагч, Монгол Улсад шууд хөрөнгө оруулагч нь Британийн Виржинийн Арлууд болон Нидерланд улсын хуулийн этгээдүүд байна. Эдгээр хөрөнгө оруулагчдын оффшор бүс дэх бүртгэл өөрчлөгдсөн үү гэдэг нь тодорхойгүй байна. Энэ тухай 2011 оны ХНГ-д ямар нэгэн заалт тусгаагүй.

1.4 2009 оны ХНГ-ний 3.1, 3.4 болон 2011 оны ХНГ-ний 4.1 болон 4.4-т “Төрийн эзэмшлийн хувьцаа 34 хувь бөгөөд түүнийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж ТӨК эзэмших”-ээр заажээ. Мөн энэ гэрээний 4.1-д “ТӨК-ийн эзэмшлийн энэ хувь хэмжээг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа шинэ хувьцаа гаргах замаар бууруулж болохгүй” гэж зааж, ТӨК буюу “Эрдэнэс МГЛ” компани өөрөө зөвшөөрч эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээг бууруулж болох боломжийг хөрөнгө оруулагч талтай тохиролцсон байна. Хэдийгээр 2009 оны ХНГ-ний 3.2 (б) болон 2011 оны ХНГ-ний 4.2 (б)-д “Одоогийн бүх хувь нийлүүлэгчид энэ гэрээний 4-т заасны дагуу төрийн эзэмшлийн хувьцааны хувьд хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхыг зөвшөөрч байна” гэж заасан нь одоогийн хувь нийлүүлэгч гэсэн тодотголтой байгааг анхаарах ёстой. Хэрэв одоогийн буюу гэрээ байгуулсан үеийн хувь нийлүүлэгч ирээдүйд өөрчлөгдвөл энэ заалт тэрхүү шинэ хувь нийлүүлэгчид хамаарахгүй байхаар байна.

Тэгээд ч 2011 оны ХНГ-ийн “Хувьцаа шилжүүлэх” гэсэн 16 дугаар зүйлд одоогийн хувь нийлүүлэгчид өөрийн эзэмшлийн хувьцааг бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлэх боломжтой зохицуулалтыг тусгажээ. Энэхүү ХНГ-ний 16.1 дэх заалт нь “Оюу толгой” компанийн аль нэг хувь нийлүүлэгч нь урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр гуравдагч этгээдэд өөрийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх боломжтой заалт гэж үзэж байна. Хэдийгээр хувь нийлүүлэгч шилжүүлэхдээ бусад хувь нийлүүлэгчид тэргүүн ээлжид санал болгох заалт 16.2 (б)-д байгаа ч Монголын тал хувьцааг худалдан авах санхүүгийн боломжгүй бол хувьцаа гуравдагч этгээдэд шилжиж, шинээр хувь нийлүүлэгч Компанид орж ирнэ. Жишээ нь, хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийн өөрийн эзэмшлийн 49 хувийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авахыг санал болгосон ОХУ-ын Засгийн газрын саналаас Монгол Улсын Засгийн газар татгалзаж байсан үйлдэл ирээдүйд давтагдахыг үгүйсгэхгүй.

1.5 2009 оны ХНГ-ний 4.3 болон 2011 оны ХНГ-ний 5.3-т зааснаар “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн 3 гишүүнийг “Эрдэнэс МГЛ” ХХК, 6 гишүүнийг Хөрөнгө оруулагч тус тус нэр дэвшүүлэн томилж байна. Мөн 2009 оны ХНГ-ний 4.4 болон 2011 оны ХНГ-ний 5.4-т зааснаар “ТУЗ-ийн гишүүн бүр саналын 1 (нэг) эрхтэй байна” гэжээ. “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн 9 гишүүний 6 нь буюу дийлэнх олонх нь гадаадын Хөрөнгө оруулагч талаас байгаа бөгөөд Монголын талын 3 гишүүн ТУЗ-ийн аливаа шийдвэрт нөлөөлөх боломжгүй байна. Тиймээс Компанийн ТУЗ дээр Монголын талын тавьсан Монгол Улсын эрх ашгийг хамгаалсан шийдвэр батлагдах боломжгүй. Тэгээд ч 2009 оны ХНГ-ний 4.6 (г) болон 2011 оны ХНГ-ний 5.6 (г)-д зааснаар ТУЗ-ийн хурлын ирц ТУЗ-ийн нийт гишүүдийн дийлэнх олонхоор буюу 6 гишүүнээр бүрдэхээр заажээ. Мөн энэ

заалтад ТУЗ-ийн 6 гишүүний ирцийг бүрдүүлэхдээ хөрөнгө оруулагч талын 4 гишүүн дээр нэмэгдэж, Айвенхоугийн хувь нийлүүлэгч 1 гишүүн болон Монголын талаас томилсон ТУЗ-ийн 1 гишүүн заавал оролцсон байх шаардлагыг тусгажээ. Үүнээс харахад ТУЗ-ийн Монголын талын 3 гишүүнээс 1 нь хуралд оролцоод байхад ТУЗ-ын хурлын ирц бүрдүүлэх шаардлага хангагдаж байна.

1.6 2009 оны ХНГ-ний 4.6 (а) болон 2011 оны ХНГ-ний 5.6 (а)-д зааснаар “ТУЗ-ийн хурал улиралд 1 удаа хуралдана, мөн аливаа 3 гишүүний хүсэлтээр түүнээс олон удаа хуралдаж болно” гэжээ. 2009 оноос хойш ТУЗ нийт хэдэн удаа хуралдаж, ямар асуудал шийдвэрлэсэн тухай мэдээлэл Зөвлөлийн Ажлын албанд байхгүй тул дүгнэлт хийх боломжгүй байна. Мөн Монголын талын 3 гишүүний хүсэлтээр “Оюу толгой” компанийн ТУЗ хэдэн удаа хуралдаж, ямар асуудал шийдвэрлэсэн тухай мэдээлэл байхгүй болохыг тэмдэглэж байна.

1.7 Тэгээд ч “Оюу толгой” компанийн ТУЗ дээр асуудал шийдвэрлэх өөр нэг боломжийг Хөрөнгө оруулагч тал эдэлж байна. 2009 оны ХНГ-ний 4.7 болон 2011 оны ХНГ-ний 5.7-д зааснаар Хөрөнгө оруулагч тал өөрсдийн томилсон ТУЗ-ийн гишүүдийн дундаас ТУЗ-ийн даргыг томилох бөгөөд мөн гэрээнд зааснаар аливаа асуудлаар ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцвэл ТУЗ-ийн дарга тухайн асуудлыг эцэслэн шийдвэрлэх саналын эрхтэй байхаар заажээ. ТУЗ-ийн даргад ийм эрх олгосон зохицуулалт Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан 2014 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсон.

1.8 “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн хурлын ирц бүрдэхгүй байх нь ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа болон гарах шийдвэрт ямар ч нөлөө үзүүлэхгүй байхаар ХНГ-нд тусгажээ. 2009 оны ХНГ-нд заасан ТУЗ-ийн ирц бүрдэх шийдвэр гаргах тухай заалтууд 2011 оны ХНГ-д хэвээр хадгалагдсан байна.

2011 оны ХНГ-ний 5.6 (г)-д “ТУЗ-ийн ирц бүрдээгүй бол ТУЗ-ийн хурлыг хойшлуулна” гэсэн ч мөн гэрээний 5.6-ын (д)-д “Хойшлогдсон хурлын ирц ТУЗ-ийн нийт гишүүдийн дийлэнх олонх хүрэлцэн ирснээр бүрдэнэ” гэжээ. Энэ заалтын дагуу хөрөнгө оруулагч тал зориуд ТУЗ-ийн хурлын ирцийг бүрдүүлэхгүй байхаар зохион байгуулж ТУЗ-ийн хурлыг хойшлуулах, хойшлогдсон ТУЗ-ийн хурлаа дан өөрсдийн 6 гишүүний ирцтэйгээр зохион байгуулж, аливаа асуудлыг шийдвэрлэх боломжтой байна. Учир нь “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн хойшлогдсон хурлын ирцэд Монголын талын 1 гишүүн заавал оролцож байж ирц бүрдэх тухай тусгайлсан шаардлага байхгүй. Үүнээс харахад “Оюу толгой” компанийн ТУЗ-д томилогдсон Монголын талын 3 гишүүн ТУЗ-ийн хурлын ирц болон аливаа шийдвэрт ямар ч нөлөө үзүүлэхгүй байхаар ХНГ байгуулжээ.

1.9 2009 оны ХНГ-ний 4.8 болон 2011 оны ХНГ-ний 5.8-д “ТУЗ-ийн шийдвэрийг тухайн хуралд оролцож байгаа саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн дэмжсэн саналаар гаргана” гэж зааснаас дүгнэхэд ТУЗ-д байгаа Монгол талын 3 гишүүн ямар ч тохиолдолд “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлөх боломжгүй, билэг тэмдэг төдий үүрэг гүйцэтгэж байна. ТУЗ-ийн Монголын талын 3 гишүүн хурлаар хэлэлцсэн асуудлаар эсрэг санал өгсөн ч хөрөнгө оруулагч талын 6 гишүүн дийлэнх олонхоор асуудлыг шийдвэрлэнэ. Мөн Монголын талын гишүүд ТУЗ-ийн хурлын ирц бүрдүүлэхгүй байх боломжгүй. Монголын талын 3 гишүүн ТУЗ-ийн хуралд очихгүй бол ТУЗ-ийн хурал хойшилно. 2011 оны ХНГ-ний 5.6-ын (д)-д зааснаар хойшилсон хурлын ирц ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх буюу хөрөнгө оруулагч талын 6 гишүүн хүрэлцэн ирснээр бүрдэж, тэрхүү 6 гишүүний дийлэнх олонх буюу 5 гишүүний саналаар ТУЗ-ийн хурлын шийдвэр батлагдана.

ТУЗ-ийн нийт гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэр гаргах аливаа асуудлыг ХНГ-ээр тохироогүй, хөрөнгө оруулагч талд давуу байдал олгожээ. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80.6-д зааснаар ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэх асуудалд тусгайлан өндөр хувь тогтоох зохицуулалтыг компанийн Дүрэмд тусгах боломжтой. Гэтэл 2009 оны ХНГ-ний 18.1 болон 2011 оны ХНГ-ний 19.1-д “ХНГ нь компанийн дүрмээс давуу байх”-аар тусгаж Монголын тал ТУЗ дээр шийдвэр гаргахад нөлөөлөх боломжтой Компанийн тухай хуулийн дээрх заалтыг ашиглахгүй байхаар баталгаажуулсан байна.

1.10 2009 оны ХНГ-ний 4.10 болон 2011 оны ХНГ-ний 5.10-д Хувь нийлүүлэгчийн хурлын шийдвэр хэрхэн гарах асуудлыг зохицуулжээ. 2011 оны ХНГ-нд 2009 оны ХНГ-нд заасныг өөрчилсөн Хувь нийлүүлэгчийн хурлын эрх хэмжээтэй холбоотой зарчмын өөрчлөлт ороогүй.

2011 оны ХНГ-ний 5.10-ын (б)-д зааснаар Хувь нийлүүлэгчийн хурлаар шийдвэрлэх асуудлыг хоёр үндсэн хэсэгт хуваасан байна. Энэхүү ХНГ-ний 5.10 (а) заалтын (i)-(vii)-д заасан асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэхдээ тухайн хуралд оролцож байгаа нийт саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшиж буй хувь нийлүүлэгчийн дэмжсэн саналаар асуудлыг шийдвэрлэхээр, үүнээс бусад асуудлыг тухайн хуралд оролцож байгаа нийт саналын эрхийн олонхийг эзэмшиж буй хувь нийлүүлэгчийн дэмжсэн саналаар шийдвэрлэхээр заажээ.

Оюу толгой төслийг хэрэгжүүлэгч “Оюу толгой” компанийн хувь нийлүүлэгчийн бүтэц нь гадаадын хөрөнгө оруулагч 66 хувь, Монголын Улсын Засгийн газар 34 хувь эзэмшдэг харьцаатай. Аль ч тохиолдолд Монголын тал хувь нийлүүлэгчийн шийдвэрт нөлөөлөх эрх зүйн боломжгүй байхаар ХНГ-ээр зохицуулжээ. Хувь нийлүүлэгчийн 100 хувийн саналаар шийдвэр гаргах аливаа асуудлыг гэрээнд тусгаагүй байна. Монгол Улсын Компанийн тухай хуулийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох” гэсэн 63.5 болон 63.8-д зааснаар тодорхой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар асуудлыг шийдвэрлэх саналын хувийг дийлэнх олонхоос дээгүүр тогтоож болох хуулийн зохицуулалт бий. Өөрөөр хэлбэл, Компанийн тухай хуулийн 62.1-62.6-д заасан (1) компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, (2) нийлүүлэх нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, (3) компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох, (4) компанийн хэлбэрийг өөрчлөх, (5) компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох, (6) хувьцааг хуваах буюу нэгтгэх) зэрэг асуудлыг Хувь нийлүүлэгчид 100 хувийн саналаар шийдвэрлэдэг байх заалтыг Компанийн дүрэмд оруулах бүрэн боломжтой байсан хэдий ч ХНГ байгуулахдаа Монголын тал хуулийн энэхүү боломжийг тусгаагүй байна.

Гадаадын хамтрагч талтай ХНГ байгуулахдаа “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн шийдвэр гаргах хуулийн механизмыг ашиглаж чадаагүй, гадаадын хөрөнгө оруулагч талд давуу байдал олгосныг Хувь нийлүүлэгчийн хурлын шийдвэр гаргах зохицуулалт хийхдээ мөн давтсан байна.

1.11 2009 оны ХНГ-ний 6.2 (а) болон 2011 оны ХНГ-ний 7.2 (а)-д зааснаар Оюу толгой компанийн ТУЗ нь АйВиЭн, эсхүл ОТН буюу тэдгээрийн нэг буюу түүнээс дээш хамаарал бүхий компанийг дангаар нь, эсхүл бүлэг болгон хамтад нь “Менежментийн баг” болгон авч ажиллуулахаар заажээ. Мөн 2011 оны ХНГ-ний 7.2 (б)-д зааснаар “Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь Менежментийн багийг өөрчлөх саналыг тухай бүр гаргаж болох бөгөөд ТУЗ нь санал болгосон Менежментийн багийг өөрчлөх, томилох асуудлыг шийдвэрлэнэ”. Гэрээний энэ заалтаас үзэхэд Монголын тал Менежментийг багийг сонгох, томилох, өөрчлөхөд оролцох эрхгүй, Менежментийн багийг зөвхөн

гадаадын Хөрөнгө оруулагч талаас санал болгож, ТУЗ-ийн шийдвэрээр томилж байна. “Оюу толгой” компанийн хувь нийлүүлэгчийн болон ТУЗ-ийн хурлын шийдвэрт Монголын тал нөлөөлөх, эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байгааг төслийг хэрэгжүүлэгч хамтрагч талууд эрх тэгш бус харилцаатай гэж дүгнэж байна.

“Оюу толгой” төслийг хэрэгжүүлэх гадаадын хөрөнгө оруулагчтай 2009 болон 2011 онд Хувь нийлүүлэгчийн гэрээ байгуулахдаа Монгол Улсын Компанийн тухай хуулиар Монголын талд боломж олгосон заалтыг ашиглаагүй, “Оюу толгой” компанийн аливаа шийдвэр гаргах эрх бүхий байгууллагууд болох Хувь нийлүүлэгчийн хурал, ТУЗ-ийн хурал, Менежментийн баг зэрэгт ямар ч эрх эдлэхгүй, гадаадын хамтрагч талд шийдвэр гаргах бүх давуу эрхийг өгсөн байна.

1.12 2009 оны ХНГ-ний 6.2 болон 2011 оны ХНГ-ний 7.2 (а), (в) болон 7.3 (а) заалтуудаас харахад Менежментийн баг нь Компанийн гүйцэтгэх удирдлагаас тусдаа бүтэц байна. Гэрээнд зааснаар “Менежментийн баг нь гүйцэтгэх удирдлагад Компанийн үйл ажиллагаа, түүний дотор үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад туслалцаа, үйлчилгээ үзүүлнэ” гэжээ. Мөн 2011 оны ХНГ-ний 7.2 (в)-д зааснаар “Менежментийн баг нь үндсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай гэж үзсэн бусад бүхий л үйлчилгээнээс бүрдэж болно” гэснээс харахад Менежментийн багийн үйл ажиллагаа нь ямар нэгэн хязгаарлалтгүй байна. “Оюу толгой” компанийн гүйцэтгэх удирдлага гэхээсээ энэхүү Менежментийн багт компанийн удирдлага, үйлдвэрлэл, санхүүгийн бодит эрх мэдэл байна.

1.13 2011 оны ХНГ-ний 7.3 (б)-д “ТУЗ нь шаардлагатай, эсхүл зүйтэй гэж үзвэл Менежментийн багийн үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд түүнтэй холбоотой ажиллана” гэжээ. Энэ заалтын дагуу “Оюу толгой” компанийн ТУЗ шаардлагатай гэж үзэж Менежментийн багийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбоотой ажиллаж байгаа юу? Монголын талын ТУЗ-ийн гишүүд энэ талаар асуудал тавьсан уу гэдэг нь тодорхойгүй, мэдээлэлгүй болно.

1.14 Мөн 2011 оны ХНГ-ний 7.3 (б)-д Менежментийн баг компанийн үйл ажиллагааны талаар ТУЗ-д улирал тутам бичгээр тайлагнана” гэжээ. ХНГ байгуулсан субъектийн хувьд Засгийн газар Менежментийн багийн тайланг ТУЗ-өөс авч, үр дүнг үнэлж дүгнэж байгаа эсэх нь тодорхойгүй.

1.15 2009 оны ХНГ-ний 6.4-т зааснаар Менежментийн багийн үйлчилгээнд “Оюу толгой” компани төлбөр төлж байна. Энэхүү гэрээний 6.4-ийн (в) хэсгийн (i)-д зааснаар ХНГ байгуулсан өдрөөс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр хүртэлх хугацаанд гарсан үйл ажиллагааны зардал болон үндсэн хөрөнгийн зардлын нийт дүнгээс 3 хувийг, мөн гэрээний 6.4-ийн (в) хэсгийн (ii)-д зааснаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойших хугацаанд гарсан үндсэн хөрөнгийн зардал болон үйл ажиллагааны зардлын нийт дүнгээс 6 хувиар тооцон төлж байна.

2011 оны ХНГ-нд энэ заалт хэвээр үлдсэн. Тухайлбал, 2011 оны ХНГ-ний 7.4-т зааснаар Менежментийн багийн үйлчилгээнд “Оюу толгой” компани улирал бүр төлбөр төлж байна. Энэхүү ХНГ-ний 7.4-ийн (в) хэсгийн (i)-д зааснаар ХНГ хүчин төгөлдөр болсон өдрөөс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр хүртэлх хугацаанд гарсан үйл ажиллагааны зардал болон үндсэн хөрөнгийн зардлын нийт дүнгээс 3 хувийг, мөн 7.4-ийн (в) хэсгийн (ii)-д зааснаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойших хугацаанд гарсан үндсэн хөрөнгийн зардал болон үйл ажиллагааны зардлын нийт дүнгээс 6 хувиар тооцон төлж байна.

Эдгээр заалтын дагуу 2009 оноос 2011 оны ХНГ байгуулагдах хүртэлх хугацаанд Менежментийн баг 3 хувийн үйлчилгээний төлбөр авна. Энэ нь мөнгөн дүнгээр хэд

болох тухай мэдээлэл байхгүй байна. “Оюу толгой” компаниас тодруулах шаардлагатай. 2009 оны ХНГ-ний 6.4 (в) (i), (ii) болон 2011 оны ХНГ-ний 7.4 (в) хэсгийн (i), (ii)-д зааснаар “Оюу толгой” компаниас Менежментийн багт төлсөн төлбөрийн хэмжээг бүрэн гаргуулан авах шаардлагатай.

2009 оны ХНГ-ний 8.1 болон 2011 оны ХНГ-ний 9.1-д “Компани (эсхүл түүний нэрийн өмнөөс Менежментийн баг) ТУЗ-ийн баталсан хөтөлбөр болон төсвийн хүрээнд компанид шаардагдаж буй мөнгөн хөрөнгийн хэрэгцээг хангах зорилгоор Хувь нийлүүлэгчид өөрийн эзэмшлийн хувь хэмжээндээ тэнцүүлэн хөрөнгө оруулах хүсэлтийг бичгээр тавьж болно” гэсэн заалтын дагуу “Оюу толгой” компанийн үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийг Менежментийн баг дангаараа тогтоож, Хувь нийлүүлэгчид өөрийн эзэмшлийн хувь хэмжээнд тэнцүүлэн мөнгөн хөрөнгө нийлүүлж байна. Энэ төлбөр нь Монголын талд өр болон үлдэж байна. Энэ төлбөрийг “Эрдэнэс МГЛ” компанийн өмнөөс Айвенхоугийн санхүүжүүлэгчид төлж, Монголын талд хүүтэй зээл болон бичигдэж, өрийн дарамтад орж байна.

1.16 2009 оны ХНГ-ийн 6.4 (д)-д зааснаар “Менежментийн баг нь өөрийн үйлчилгээний тодорхой хэсгийг АйВиЭн, эсхүл ОТН-ийн хамаарал бүхий компани шилжүүлж, эсхүл тэдгээрээр туслан гүйцэтгүүлж болно” гэж, мөн ХНГ-ний 6.4 (ё)-д “Айвенхоугийн хувь нийлүүлэгчид хамтдаа, эсхүл тэдгээрийн аль нэг нь Менежментийн багийг төлөөлж болон түүний нэрийн өмнөөс энэхүү гэрээг хэрэгжүүлж болно” гэсэн заалт 2011 оны ХНГ-нд хэвээр үлдсэн байна. Тухайлбал, 2011 оны ХНГ-ний 7.4 (д)-д зааснаар “Менежментийн баг нь өөрийн үйлчилгээний тодорхой хэсгийг АйВиЭн, эсхүл ОТН-ийн хамаарал бүхий компани шилжүүлж, эсхүл тэдгээрээр туслан гүйцэтгүүлж болно” гэж, мөн ХНГ-ний 7.4 (ё)-д “Айвенхоугийн хувь нийлүүлэгчид хамтдаа, эсхүл тэдгээрийн аль нэг нь Менежментийн багийг төлөөлж болон түүний нэрийн өмнөөс энэхүү гэрээг хэрэгжүүлж болно” гэжээ.

Дээрх заалтуудыг судлан үзэхэд Менежментийн баг нэрээр хөрөнгө оруулагч тал өөртөө түүний эрхийг авч, Менежментийн үйлчилгээ нэрээр төлбөр авах боломжтой болжээ. Менежментийн баг нь гадаадын хамтрагч талын халхавч төдий бүтэц гэж дүгнэж байна. Компанийн гүйцэтгэх удирдлага өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж байхад ийм зардал ихтэй, давхардсан бүтэцтэй байх шаардлагагүй гэж үзэж байна. Компанийн гүйцэтгэх удирдлагын дээр Менежментийн баг гэдэг удирдлагын давхар бүтэц ажиллаж, улирал тутам үйл ажиллагааны зардлын 6 хувиар тооцож төлбөр авч байна.

Энэхүү Менежментийн багийн бүрэлдэхүүн болон бусад холбогдох мэдээллийг бүрэн хэмжээгээр авах шаардлагатай. Мөн Менежментийн баг өөрийн үүргийг бүхэлд нь болон хэсэгчлэн АйВиЭн-д шилжүүлсэн үү? Эсхүл ОТН-ийн хамаарал бүхий компанид шилжүүлсэн болон тэдгээрээр тусган гүйцэтгүүлж байна уу зэрэг мэдээллийг авч, дүгнэлт хийх шаардлагатай.

1.17 2009 оны ХНГ-ийн 7.1 болон 2011 оны ХНГ-ний 8.1-д зааснаар Компани, эсхүл (Менежментийн баг) Компанийн үйл ажиллагааны хөтөлбөр болон төсвийг ТУЗ-д хүргүүлж батлуулж байна. Ялангуяа, ХНГ-ийн 8.1 (а)-д зааснаар “Компанийн үйл ажиллагааны анхны хөтөлбөр, төсвийг ТУЗ-д хүргүүлнэ” гэжээ. Компанийн үйл ажиллагаагаа эхэлснээс хойших ТУЗ-өөр баталсан жил бүрийн үйл ажиллагааны хөтөлбөр болон төсвийг нягтлан, бодит үр дүнг шалган тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн ХНГ-ийн 8.1 (г)-д зааснаар “Шаардлагатай тохиолдолд Компани (эсхүл Менежментийн баг) нь шинэчлэн найруулсан, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулсан хөтөлбөр болон төслийг боловсруулж ТУЗ-д батлуулахаар хүргүүлж болно” гэж заасны дагуу шинэчлэн найруулсан, нэмэлт өөрчлөлт оруулсан хөтөлбөр, төсөв байгаа эсэхийг

“Оюу толгой” компаниас тодруулж, шалтгааныг тогтоож, үр дүнг шалгах ёстой гэж үзэж байна.

1.18 2011 оны ХНГ-ний 8.2 (а), (б)-д заасан менежментийн болон санхүүгийн бүх тайланг “Оюу толгой” компаниас шаардан гаргуулж бодит үр дүнг шалган тогтоох шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн мөн гэрээний 8.2 (г)-д зааснаар Монголын талын хувь нийлүүлэгч болон ТУЗ-ийн гишүүний шаардаж авсан бусад мэдээлэл байгаа эсэхийг “Оюу толгой” компанийн ТУЗ-өөс тодруулж, Монголын талын ТУЗ-ийн гишүүд эрх ашгаа хэрхэн хамгаалж байсныг тодруулах нь зүйтэй.

1.19 2009 оны ХНГ-ний 8.1 болон 2011 оны ХНГ-ний 9.1-д “Компани (эсхүл түүний нэрийн өмнөөс Менежментийн баг) ТУЗ-ийн баталсан хөтөлбөр болон төсвийн хүрээнд компанид шаардагдаж буй мөнгөн хөрөнгийн хэрэгцээг хангах зорилгоор Хувь нийлүүлэгчид өөрийн эзэмшлийн хувь хэмжээндээ тэнцүүлэн хөрөнгө оруулах хүсэлтийг бичгээр тавьж болно” гэж заасан байна. Мөн гэрээний 9.2-т мөнгөн хөрөнгийн санхүүжилтийн хэлбэрийг тодорхойлжээ. Энэ заалтын дагуу Компани мөнгөн хөрөнгийн санхүүжилтийг (1) энгийн хувьцааны хэлбэрээр буюу хувьцаа нэмж гаргах замаар, (2) хувь нийлүүлэгчдийн өрийн хэлбэрээр гэсэн 2 аргаар хийхээр тогтжээ. Харин 2009 оны ХНГ-нд байсан “давуу эрхтэй хувьцааны хэлбэрээр давуу эрхийн хувьцаа нэмж гаргах замаар” санхүүжилт хийх аргыг 2011 оны ХНГ-ээр хассан байна. Ингэснээр Компанийн санхүүжилтийн хэлбэр нь зөвхөн энгийн хувьцаа нэмж гаргах, эсхүл өрийн хэлбэрээр гэсэн 2 төрөлтэй болжээ.

ХНГ-ний 9.3 (б)-д зааснаар Компанийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр “Шаардсан мөнгөн хөрөнгийн бүх нийлүүлэлтийг америк доллараар хийх”-ээр тохирчээ. 2009 оны ХНГ-нд байсан энэ заалт 2011 оны ХНГ-нд хэвээрээ үлдсэн байна. Хэдийгээр энэ заалтад өөр валютаар хийхийг ТУЗ шийдвэрлэнэ гэж заасан боловч “валют” гэж зааснаас харахад төгрөгөөр санхүүжилт хийхгүй ажээ. Тэгээд ч “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн шийдвэрт Монголын тал нөлөөлөх эрх зүйн боломжгүй гэдгийг дахин тэмдэглэж байна.

“Оюу толгой” төсөлд америк доллараар санхүүжилт хийгдсэнээр долларын ханшны өсөлтөөс Монголын тал алдагдал хүлээж байна. Ийнхүү 2009 оноос хойш ханшны зөрүүгээр өнөөдрийг хүртэл Монголын талын хүлээсэн алдагдлыг тооцож гаргах шаардлагатай.

1.20 2009 оны ХНГ-ний 8.3 (а) болон 2011 оны ХНГ-ний 9.3 (а)-д зааснаар “Оюу толгой” компанид нийлүүлэхээр шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх Айвенхоугийн хувь нийлүүлэгчийн үүргийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгч, эсхүл Айвенхоугийн өөр хувь нийлүүлэгч гүйцэтгэж болохыг талууд зөвшөөрсөн байна. Өөрөөр хэлбэл, энэ заалтыг Монголын тал зөвшөөрсөн байна. Эндээс харахад Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй “АйВиЭн” компаниар дамжин мөнгөн хөрөнгө орж ирэх ажээ. Харин АйВиЭн-д уг мөнгөн хөрөнгийг нийлүүлэгч нь санхүүжүүлэгч гэх ямар нэгэн санхүүгийн байгууллага, хуулийн этгээд байж болохоор байна.

Ингэснээр гадаадын хөрөнгө оруулагч нь бүр эхнээсээ өөрийн мөнгөн хөрөнгөөр, хөрөнгө оруулалтаар биш санхүүжүүлэгч байгууллагын хүүтэй зээлээр “Оюу толгой” төслийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ гэж үзэж байна. Энэ тохиолдолд санхүүжилтийн зээл, түүнийг хүүг төлөх үүргийг хувь нийлүүлэгч хүлээж байгааг өөрчилж, тодорхой болгох нь чухал. Айвенхоу нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр биш санхүүжүүлэгчийн зээлээр “Оюу толгой” компанийг санхүүжүүлсэн тохиолдолд зээл, зээлийн хүүг “Оюу толгой” компани хуулийн этгээдийн хувьд хариуцаж, өөрийн үйл ажиллагаанаас төлөх нь бизнесийн зарчимд нийцнэ.

2009 оны ХНГ-ний 8.2 (в) болон ХНГ-ний 9.2 (б)-д зааснаар “Хувь нийлүүлэгчдийн өрийн хэлбэрээр” “Оюу толгой” компанийг санхүүжүүлжээ гэж дүгнэж байна. ХНГ-ний эдгээр заалтын дагуу Компанийн мөнгөн хөрөнгийн санхүүжилтийг ямар аргаар хэрхэн хэрэгжүүлж байгаа болон Монголын талын өөрийн эзэмшлийн 34 хувьд тэнцүүлэн тооцсон мөнгөн хөрөнгийн хэмжээ, түүнийг хэрхэн бүрдүүлсэн болохыг тооцон ашиг, алдагдлын харьцааг гаргаж, төслийн санхүүжилтийн үр ашгийг тооцох шаардлагатай.

1.21 2009 оны ХНГ-ний 8.7-д Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүү гэдэг заалт орсон байна. Энэ заалтаар гэрээ байгуулж байгаа хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцож эхлэнэ гэж заажээ. ХНГ-ний нэр томъёоны тодорхойлолт хэсэгт “Хувь нийлүүлэгчийн одоогийн зээл” гэдгийг тодорхойлохдоо “Хувь нийлүүлэгчийн одоогийн зээл гэж гэрээ хүчин төгөлдөр болох өдөр хүртэлх хугацаанд “Оюу толгой” төсөл болон үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан “Айвенхоу групп”, эсхүл “Рио тинто групп”-ээс Компанид урьдчилан олгосон бүх санхүүжилт (дүнг Хөрөнгө оруулалтын гэрээний 15.7.5 дахь заалтын дагуу тодорхойлно) (тухайн санхүүжилтийн олгосон нөхцөл болон түүнийг Компанийн үйл ажиллагаанд зарцуулсан эсэхээс үл хамааран)-ыг хэлэх бөгөөд энэхүү санхүүжилтийн дүнд 9.9 хувиар тооцсон хүү багтана. Чингэхдээ энэ хүү нь АНУ-ын үнийн индексийн өмнөх улирлын хэлбэлзлийн хувиар улирал тутам тогтоодог хувиудын нийлбэрээр тодорхойлогдоно” гэснээс үзэхэд 2009 онд анх энэхүү Хувь нийлүүлэгчийн гэрээг байгуулахдаа санхүүжилтийг хүүтэй зээлээр хийхээр төлөвлөсөн нь батлагдаж байна. “Оюу толгой” компанийн 34 хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч Монголын тал үүнд хамаарна. Ингэснээр Монголын тал энэхүү байгуулж байгаа ХНГ хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацаанд (Монголын тал хувь нийлүүлэгч болоогүй байхад зарцуулсан мөнгө) “Оюу толгой” төсөлтэй холбоотой “Айвенхоу групп” болон “Рио Тинто групп”-ээс Компанид урьдчилан олгосон бүх санхүүжилт болон түүний хүү 9.9 хувийн хүүг төлөх үүргийг хуваалцахаар тохиролцжээ. Тэгээд ч тэрхүү санхүүжилт нь “Оюу толгой” компанийн үйл ажиллагаанд зарцуулсан эсэхээс үл хамаарч байхыг зөвшөөрсөн нь шударга бус бөгөөд энэ заалтын дагуу компанийн үйл ажиллагаанд зарцуулаагүй мөнгө хөрөнгийг зөвшөөрөхгүй байх нь зүйтэй.

Иймд 2009 оны ХНГ-г байгуулахаас өмнө “Оюу толгой” төсөлд зарцуулсан гэх мөнгөн дүн, хүүгийн хамт хэд болсон, энэ мөнгөн дүнгийн хэдэн хувь нь Монголын талын төлөх өр болсон эсэхийг дахин эргэж нягтлан шалгах нь зүйтэй байна.

Энэхүү зээлтэй холбоотой заалт 2011 оны ХНГ-нд мөн давтагдсан байна. 2011 оны ХНГ-ний 9.7-д “Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүү” гэж заажээ. Энэ заалтаар хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцож эхлэнэ гэж заажээ. Энэ заалт 2009 оны ХНГ-нд мөн энэ томъёоллоор тусгагдсан.

Мөн 2011 оны ХНГ-нд “Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийг хөрвүүлэх” гэсэн 9.8 дугаар зүйл нэмэлтээр оржээ. Энэ нэмэлтээр (а) Айвенхоугийн хувь нийлүүлэгчид Компани болон бусад хувь нийлүүлэгч тус бүрд мэдэгдэл өгөх замаар (i) Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг энэхүү гэрээний 9.8 (б)-д заасны дагуу хувьцаанд хөрвүүлэх ба/ эсхүл, (ii) хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг энэхүү гэрээний 13.1 -д заасан хувь нийлүүлэгчдийн зээл гэж тооцож болох шийдвэрийн аль нэгийг хэдийд ч гаргаж болж байна. Ингэж шийдвэрлэсэн тохиолдолд энэхүү Гэрээний 13.1 (г)-13.1 (е) дэх заалтууд хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлд үйлчилнэ.

Хэрэв АйВиЭн-ийн хувь нийлүүлэгчид хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг гэрээний 9.8 (а) (i)-д заасны дагуу хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсэн бол (i)

хөрвүүлэх үед Компани хөрвүүлэх өдрийн байдлаар хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийн нийт дүн (түүний дотор зээлийн үндсэн дүн, төлөгдөөгүй болон хуримтлагдсан бүх хүү)-тэй тэнцүү (*Зээлийг хөрвүүлэх дүн*) тооны хувьцаа гаргаж, (ii) уг хувьцааг хувь нийлүүлэгч тус бүрийн эзэмшлийн хувь хэмжээнд хувь тэнцүүлэн хуваарилна гэжээ.

Энэхүү зээлийг хөрвүүлэх дүнгийн ТӨК-ийн буюу “Эрдэнэс МГЛ” компанийн эзэмшлийн хувь хэмжээнд ногдох хэсгийг санхүүжүүлсэн дүн гэж үзэх бөгөөд үлдэгдэл дүн (энэхүү гэрээний 11.1 (г)-д заасны дагуу ийнхүү тооцсон санхүүжүүлсэн дүнд зээлийн гэрчилгээ олгоно)-д нэмж тооцно” гэжээ. Үүнээс харахад Монголын талын 34 хувьд ногдох мөнгөн санхүүжилт нь хүүтэй, зээл болохыг дахин баталж, ХНГ-нд тусгажээ.

1.22 2009 оны ХНГ-ний 9 дүгээр зүйлд санхүүжилтийн зохицуулалтыг заажээ. Санхүүжилтийг санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгө, санхүүжилтийн хугацааны дараах үе гэж хоёр үндсэн хэсэгт хувааж авч үзсэн байна. ХНГ-ний 9.1-д санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгийн тухай зааж, санхүүжилтийн тохиролцоог хийсэн бөгөөд санхүүжилтийн хугацаанд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр нийлүүлэхээр заажээ. Үүнээс харахад “Оюу толгой” төслийг санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийг “АйВиЭн” компани бүр эхнээсээ өөрийн санхүүжүүлэгчээс зээл хэлбэрээр авахаар төлөвлөжээ гэдгийг дахин онцлон тэмдэглэж байна. Тиймээс “Айвенхоугийн хувь нийлүүлэгчид энэхүү гэрээний 8.2-т заасан аль нэг хэлбэр, хэлбэрүүдийг тодорхойлохоор Талууд тохиролцов” гэснээр санхүүжилтийн хэлбэрийг сонгох эрхийг Айвенхоугийн хувь нийлүүлэгчид зөвшөөрчээ. Нэгэнт санхүүжилтийн хугацаанд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр, өөрийн тодорхойлсон хэлбэрээр нийлүүлэхээр заасан байхад ХНГ-ний 8.2-т заасан “Хувь нийлүүлэгчийн өрийн хэлбэр”-ийг Айвенхоугийн хувь нийлүүлэгчид тодорхойлох нь ойлгомжтой юм.

“Оюу толгой” төсөлд Айвенхоу шууд хөрөнгө оруулалт хийхгүй, зээлийн санхүүжилт хийх боломж олгосон заалт оруулж, түүнийг баталгаажуулах хэлбэрээр гэрээг байгуулсан байна.

Энд заасан “Санхүүжилтийн хугацаа” гэдэг нь гүйцэтгэлийн өдрөөс (ХНГ-ний нэр томъёоны тодорхойлолтод зааснаар “Энэ гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойших 21 дэх ажлын өдөр, эсхүл талуудын харилцан тохиролцсон гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойших өөр өдрийг хэлнэ”) хойш 3 жил өнгөрөх хүртэлх хугацааг хэлнэ” гэжээ. Үүнээс харахад “Оюу толгой” төслийн санхүүжилтийг энэхүү ХНГ байгуулагдаж хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн хугацаанд Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй “АйВиЭн” компанийн санхүүжүүлэгч бүрэн хэмжээгээр зээлээр хийхээр болжээ.

“Оюу толгой” төслийн санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгийг гаргасан Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй “АйВиЭн” компанийн санхүүжүүлэгч хэн болох, түүний санхүүжилтийн мөнгө дүн, санхүүжилтийн нөхцөлийн тухай мэдээллийг ил болгох шаардлагатай.

2011 оны ХНГ-ний 10 дүгээр зүйлд санхүүжилтийн зохицуулалтыг хэвээр нь заажээ. Тухайлбал, санхүүжилтийг санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгө (ХНГ-ний 10.1), санхүүжилтийн хугацааны дараах үе (ХНГ-ний 10.2) гэж хоёр үндсэн хэсэгт хуваасан нь хэвээр байна. ХНГ-ний 10.1-д санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгийн тухай зааж, санхүүжилтийн тохиролцоог хийсэн бөгөөд ТӨК заавал мөнгөн хөрөнгө гаргах үүрэг хүлээхгүйгээр (гаргаж болно) санхүүжилтийн хугацаанд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь (энэхүү гэрээний 11.1 (энгийн хувьцаа гаргах) болон 13.1 (Хувь

нийлүүлэгчийн зээл) заасны дагуу ТӨК өөрийн хэсгийг нийлүүлэх шийдвэр гаргах эрхийг харгалзан) нийт шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр нийлүүлэх бөгөөд Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь энэхүү гэрээний 9.2-т заасан санхүүжилтийн аль хэлбэр, эсхүл хэлбэрүүдийг эдгээр нийлүүлэлтийн хувьд хэрэглэхийг тодорхойлно” тохиролцжээ.

“Оюу толгой” төслийг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим удирдамжийг баталсан УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолд “Ордыг түшиглэн байгуулагдах компанийн хувьцааны 34 хувийг Монголын тал шууд эзэмшихээр тооцож, уг хувьцаанд ногдох хөрөнгийг албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, зээл зэрэг хэлбэрээр оруулж болохоор тохиролцох” гэж заажээ. УИХ-аас тогтоосон дээрх аргуудаас зөвхөн “зээл” хэлбэрийг дангаар сонгосон нь өрийн дарамт үүсгэсэн оновчгүй тохиролцоо болжээ гэж дүгнэж байна.

1.23 2011 оны ХНГ-ний 10.2-т санхүүжилтийн хугацааны дараах үед буюу гэрээний 10.1-д заасан санхүүжилтийн хугацаа дууссаны дараа хийх мөнгөн хөрөнгийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулжээ. Ингэхдээ энэ хэсэгт “Компани нь шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлтийг хэдийд ч тавьж болно. Хэрэв ТӨК энэхүү гэрээний 11.1 (а), эсхүл 13.1 (а)-д заасны дагуу шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд (эсхүл ингэж шийдвэрлэсэн гэж тооцох тохиолдолд) Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь энэхүү гэрээний 11.1 (в), эсхүл 13.1 (в)-д заасны дагуу ТӨК-ийн нийлүүлэхгүй байхаар шийдсэн хэсгийг нийлүүлж болно. (Гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй) Энэ тохиолдолд Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь энэхүү гэрээний 11 болон 13-т заасан санхүүжилтийн хэлбэрүүдийн аль хэлбэрийг хэрэглэхийг тодорхойлох бөгөөд ийнхүү тодорхойлсон хэлбэрийг ТӨК болон Компани хүлээн зөвшөөрнө” гэж заажээ.

Энэ заалтаар Айвенхоугийн аувь нийлүүлэгчид нь санхүүжилтийг бүрэн хэмжээгээр өөрийн сонгосон хэлбэрээр хийж байна. Гэхдээ үүнийг заавал хэрэгжүүлэх үүрэг болголгүй, өөртөө давуу байдал авч үлдсэн байна. Ингэснээр санхүүжилттэй холбоотой хариуцлага хүлээхгүй, өөрийн үзэмжээр ажиллах боломжтой давуу талтай болжээ. Аль ч тохиолдолд санхүүжилтийн хугацаанд ч тэр, санхүүжилтийн дараах үед тэр “Оюу толгой” төслийн санхүүжилтийн хөрөнгийг АйВиЭн-н санхүүжүүлэгч, эсхүл Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид өөрийн үзэмжээр шийдвэрлэж, түүнийг нь “Эрдэнэс МГЛ” болон “Оюу толгой” компани хүлээн зөвшөөрнө гэдгийг тохирчээ.

2009 оны ХНГ-нд байсан энэ зүйлийг 2011 оны ХНГ-ээр тодотгон найруулж дугаар нь 10.2 болж өөрчлөгдсөн байна. Уг өөрчлөлтөөр гэрээний зарим зүйл, заалт өөрчлөгдсөнийг залруулж бичсэн, давуу эрхийн хувьцаа нэмж гаргах санхүүжилтийн арга хасагдсаныг тодруулсан байна. Гэхдээ зарчмын хувьд нэмж оруулсан нэг асуудал нь 2009 оны ХНГ-д байсан дээрх заалтууд дээр нэмж “ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд Айвенхоугийн хувь нийлүүлэгчид ТӨК-д ногдох шаардсан мөнгөн хөрөнгийг, түүнчлэн өөрийн эзэмшлийн хувь хэмжээнд ногдох шаардсан мөнгөн хөрөнгийг санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй” гэсэн заалт нэмж, улмаар “ийм нөхцөл байдал үүссэн үед ТУЗ санхүүжилтийн бусад арга хэлбэрийг тодорхойлно” гэж тусгасан байна.

2009 оны ХНГ-д заахдаа Айвенхоугийн хувь нийлүүлэгчид санхүүжилтийн эрхийг бүрэн өөртөө авч байсан бол 2011 оны нэмэлт, өөрчлөлтийн гэрээгээр энэ эрхээ хэрэгжүүлж болох хувилбараас гадна эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаад ТУЗ-ийн хурлаар санхүүжилтийн бусад арга хэлбэрийг тодорхойлох хувилбарыг оруулсан байна. Айвенхоугийн гишүүд ТУЗ-ийн дийлэнх олонхийг бүрдүүлж, дангаараа шийдвэр гаргах

эрхтэй учир ТУЗ-ийн шийдвэр нь Айвенхоугийн хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хангасан хэлбэрээр гарах нь тодорхой бөгөөд Монголын талд ашигтай байдал үүсгэхгүй.

“Оюу толгой” компанийн удирдлагын шийдвэр гаргах болон төслийн санхүүжилттэй холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд Монголын тал ямар ч нөлөөгүй байна. Хөрөнгө оруулагч тал өөртөө Компанийн удирдлага, санхүүжилт, үйлдвэрлэл, санхүүжилтийн үйл ажиллагаа зэрэг бүхий л үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг өөрийн үзэмжээр бие даан гаргахаар 2009 оны болон 2011 оны ХНГ-нд тусгажээ.

Харин 2011 оны ХНГ-д (в) “Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс ТӨК шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд түүний эзэмшлийн хувь хэмжээ (төрийн эзэмшлийн хувьцааг гарган ТӨК-д шилжүүлсний дараах 34 хувь)-г бууруулж болохгүй. (г) “Энэхүү гэрээний 10.2-ын аливаа заалт нь ТӨК-аас шаардсан мөнгөн хөрөнгийг санхүүжүүлэх ТӨК-ийн эрхийг хязгаарлахгүй бөгөөд Компани ийнхүү санхүүжүүлснийг нь хүлээн зөвшөөрнө” гэсэн 2009 оны хуучин заалтууд хэвээр үлдсэн байна.

1.24 2009 оны ХНГ-ний 9.2(в)-д “Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс ТӨК шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд түүний эзэмшлийн хувь хэмжээг бууруулж болохгүй” гэж заасан, мөн 2011 оны ХНГ-ний 10.2-т “Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс ТӨК шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд түүний эзэмшлийн хувь хэмжээ (төрийн эзэмшлийн хувьцааг гарган ТӨК-д шилжүүлсний дараах 34 хувь)-г бууруулж болохгүй” гэж тодотгон заасан нь Монголын талын эзэмших хувьцааны хувь хэмжээ буурахгүй байх эрх ашгийг хангаж байгаа хэдий ч энэ нь мөнгөн хөрөнгө гаргахгүй гэсэн үг биш юм.

Учир нь 2009 оны ХНГ-ний 10.1 (а)-д зааснаар санхүүжилтийн хугацаанд болон түүний дараа хувь нийлүүлэгчид нь шаардсан мөнгөн хөрөнгө бүрт өөрийн эзэмшлийн хувь хэмжээний дагуу хөрөнгө нийлүүлнэ” гэж үүрэг хүлээжээ. Гэхдээ мөн ХНГ-ний 10.1 (б) хэсгийн (i), (ii)-т зааснаар АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь Монголын талын өмнөөс төлөхөөр заажээ. Энэхүү санхүүжилттэй холбоотой ойлгомжгүй зохицуулалтыг ХНГ-ний 10.1 (а)-д заажээ. Энэ заалтад Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь санхүүжилтийг хийхдээ энгийн хувьцаа гаргах аргыг тодорхойлсон бол “Эрдэнэс МГЛ” нь 3 жилийн хугацаанд шаардсан мөнгөн хөрөнгийг хийх эрхээ эдлэхгүй, харин 3 жил өнгөрсний дараа шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд буюу хэсэгчлэн нийлүүлж болно (гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй) гэжээ. Монголын талын эрхийг хязгаарласан энэхүү заалт нь ХНГ-ний 10.1 (б) хэсгийн (i), (ii)-т заасан Монголын талын өмнөөс АйВиЭн-ийн санхүүжүүлэгч төлөх заалтаар тайлбарлагдаж байна.

Хөрөнгө оруулагч тал Монголын талын хувь нийлүүлэгчийг аль болох өөрөөсөө санхүүгийн хувьд хараат, өртэй, хамааралтай байлгах бодлого эхнээсээ явуулжээ дүгнэж байна. Өөрөөр хэлбэл, төслийн санхүүжилтийг бүх хэлбэрийг Айвенхоугийн хувь нийлүүлэгч өөрөө сонгох, түүний санхүүжүүлэгчээс зээл хэлбэрээр авч байх, Монголын талын хувь нийлүүлэгч нь зөвхөн энэ эх үүсвэрээс санхүүжилт авч өр үүсч байхаар зохион байгуулсан байна.

Ингэснээр Монголын тал гадаадын хамтрагч талаас санхүүгийн бүрэн хараат байдалд орж, санхүүгийн хувьд ямар нэгэн байдлаар Монголын тал бие даасан үйл ажиллагаа явуулах боломжгүйгээр зохицуулалт хийжээ. Энэ нь 2009 оны ХНГ-ний 10.1 (ж) заалтаар батлагдаж байна. Энэ заалтаар шаардсан мөнгөн хөрөнгийг ТӨК нь өөрөө нийлүүлэх тохиолдолд Айвенхоугийн хувь нийлүүлэгчтэй зөвлөлдөх бөгөөд гэрээнд зааснаар 1-д ““Оюу толгой” төслийг санхүүжүүлэх Айвенхоу группийн төлөвлөгөөнд

сөргөөр нөлөөлөхгүй гэж Айвенхоугийн хувь нийлүүлэгчид үзсэн” (ХНГ-ний 10.1 (ж) хэсгийн (i) заалт), 2-т “ТӨК-ийн нийлүүлэх хөрөнгийн санхүүжилтийн нөхцөл болзлыг Айвенхоугийн хувь нийлүүлэгчид зөвшөөрсөн”(ХНГ-ний 10.1 (ж) хэсгийн (ii) заалт), 3-т “Компанийн хувьд ТӨК-ийн санхүүжилтийн нөхцөл болзол нь АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нөхцөл, болзлоос илүү тааламжтай байвал” (ХНГ-ний 10.1(ж) хэсгийн (iii) заалт) гэжээ. Гэхдээ эдгээр 3 нөхцөл бүгд хангагдсан тохиолдолд хэрэгжинэ гэж хязгаарлалт тогтоожээ. Өөрөөр хэлбэл, эдгээр 3 нөхцөлийн аль нэгийг нь хангахгүй тохиолдолд Монголын тал өөрийн, эсхүл өөрийн олсон эх үүсвэрээр мөнгөн санхүүжилт хийх боломжгүй байхаар зохицуулжээ. Гэтэл гадаадын хөрөнгө оруулагч талын санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийн нөхцөлд Монголын талаас ямар ч нөхцөл заагаагүй байна. Харилцан ашигтай хамтын ажиллагаагүй, гэрээний эрх тэгш байдлыг хангаагүй гэж үзнэ.

2011 оны ХНГ-нд энэхүү зохицуулалт зарчмын хувьд өөрчлөгдөөгүй. 2011 оны ХНГ-ний 10.1 (а)-д зааснаар Монголын тал шаардсан мөнгөн хөрөнгийн өөрт ногдох хэсгийг нийлүүлэх шийдвэр гаргах эрхтэй (гэхдээ ийм үүрэг хүлээхгүй)” гэжээ. Мөн ХНГ-ний 10.1 (б) зааснаар АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт шаардсан хөрөнгийг бүрэн хэмжээгээр, санхүүжилтийн хэлбэрийг өөрөө тодорхойлж нийлүүлэхээр заажээ.

1.25 2009 оны ХНГ-ний “Энгийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийх” гэсэн 10 дугаар заалтыг 2011 оны нэмэлт, өөрчлөлтөөр 11 болгон өөрчилж, шинээр оруулж нэмж тодотгосон байна.

2011 оны ХНГ-ний 11.1-д “ТӨК-аас шаардсан мөнгөн хөрөнгийг энгийн хувьцаа гаргах замаар санхүүжүүлэх” гэсэн заалтад (а) Айвенхоугийн хувь нийлүүлэгчид (санхүүжилтийн хугацааны туршид), эсхүл ТУЗ (санхүүжилтийн хугацаа дууссаны дараа) энгийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийхээр тодорхойлсон тохиолдолд ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгө бүрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхээр шийдвэрлэж болно (гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй). ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухайгаа Компани болон Айвенхоугийн хувь нийлүүлэгчдэд урьдчилан бичгээр (шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 5 (таван) ажлын өдрийн дотор) мэдэгдэнэ. Хэрэв ТӨК энэ хугацаанд нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн бол ТӨК түүнээс шаардсан хөрөнгийн холбогдох хэсгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэнд тооцогдоно” гэж өөрчлөн найруулж, шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх 5 хоногийн хугацаа өгсөн зохицуулалт шинээр оруулж, энэ хугацаа өнгөрмөгц санхүүжилт хийхгүй байх шийдвэр гарсанд тооцох шахуу хугацааг зааж зохицуулжээ.

Энэ зохицуулалттай холбогдуулан Айвенхоугийн хувь нийлүүлэгчид мөн адил эрх олгосон заалтаар өөрийн эзэмшлийн хувь хэмжээнд ногдох шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухайгаа Компани болон ТӨК-д бичгээр (шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 5 (таван) ажлын өдрийн дотор) урьдчилж мэдэгдэнэ. Хэрэв Айвенхоугийн хувь нийлүүлэгчид энэ хугацаанд ийм шийдвэр гаргаагүй бол энэхүү гэрээний 10.2 (а)-д заасныг харгалзан түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхээр шийдвэрлэсэн гэж үзнэ” гэж заажээ. Санхүүжилтийн хугацааны туршид хэрэв ТӨК энгийн хувьцаа гаргах замаар түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (эсхүл шийдвэрлэсэн гэж тооцогдох) бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгч ТӨК-аас шаардсан мөнгөн хөрөнгийн ТӨК-ийн нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн хэсгийг энэхүү гэрээний 11-д заасны дагуу ТӨК-ийн нэрийн өмнөөс Компанид төлж байна.

Ийнхүү АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн ТӨК-д хувьцаа олгосон мөнгөн дүн тус бүр нь *санхүүжүүлсэн дүн* болох бөгөөд энэ тохиолдолд Компани санхүүжүүлсэн дүнг гэрчилсэн *Зээлийн гэрчилгээг* АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хувь нийлүүлэгч бүрд) олгох ажээ.

АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь Монголын талын хувь нийлүүлэгчийг аль болох өөрөөсөө хараат, өртэй, хамааралтай байлгах бодлогыг 2011 оны ХНГ-ээр үргэлжлүүлсэн гэж үзнэ.

2009 оны ХНГ-ний 10.1 (ж) заалт 2011 онд арай уян хатан хэлбэртэй болж, дараах хэлбэрээр өөрчлөгдсөн байна. Үүнд: “Мөн 2011 оны ХНГ-ээр 11.1(з)-д “Санхүүжилтийн хугацааны туршид ТӨК-аас шаардсан мөнгөн хөрөнгийг энэхүү гэрээний 11,13-т заасны дагуу ТӨК өөрөө нийлүүлэх эрхтэй бөгөөд ТӨК-ийн сонгосон санхүүжилтийн арга хэлбэрийн нөхцөл, болзол нь тухайн үеийн болон ирээдүйд авахаар төлөвлөж буй төслийн аливаа санхүүжилтэй зөрчилдөхгүй, эсхүл саад болохгүй байхын зэрэгцээ АйВиЭн-ийн Компанид хийсэн санхүүжилтийн нөхцөл, болзлоос дутуугүй байна” өөрчлөн найруулжээ. Хэдийгээр “Эрдэнэс МГЛ” ийм эрхтэй гэсэн ч энд заалтад байгаа нөхцөлүүдээс харахад хэрэгжих боломж хязгаарлагдмал байна.

1.26 2009 оны ХНГ-ний “Санхүүжүүлсэн дүн” гэдэг 10.2 дахь заалт 2011 оны ХНГ-ээр 11.2 дахь заалт болж өөрчлөгдөж, түүний (а)-д “АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн санхүүжүүлсэн дүнгүүд энэхүү гэрээний 11.3-д заасны дагуу санхүүжилтийн хүүгийн хувиар хүү тооцох бөгөөд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч (эсхүл хэрэв Айвенхоугийн хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОН) энэхүү гэрээний 11.4-т заасны дагуу үлдэгдэл дүн дуусгавар болох хүртэл төлбөр хүлээн авах эрхтэй. Гэхдээ энэ эрх нь энэхүү гэрээний 16.6 (в) болон 16.7 (б)-д заасны дагуу үлдэгдэл дүнг бүхэлд нь хүлээн авах АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн эрхийг, эсхүл энэхүү гэрээний 11.4 (г) заалтын дагуу үлдэгдэл дүнг бууруулах боломжийг хязгаарлахгүй” гэж өөрчлөн найруулсан бол мөн (б)-д “Нийт санхүүжилтийн хувьцааны нийлбэр нь Компанийн нийт хөрөнгийн 60 (жаран) хувиас хэтрэхгүй байна” гэж шинэчлэн найруулжээ.

Дээрх заалтаар Монголын талын хувь нийлүүлэгчийн өмнөөс төлж байгаа АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн санхүүжүүлсэн бүх дүнд хүү төлнө. Монгол Улс өөрийн эзэмшлийн 34 хувийг болон “Оюу толгой” компанийн үйл ажиллагааны санхүүжилтийн өөрт ногдох хэсэгт өр үүсгэн өөртөө үүрэг хүлээж байна. Энэ заалт нь 2011 оны ХНГ-ний “Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийг хөрвүүлэх” гэсэн 9.8 дугаар зүйлээр баталгаажиг байна.

Мөн 2011 оны ХНГ-ийн 11.3 (а)-д зааснаар санхүүжилтийн үлдэгдэл төлбөрт улирал тутам тооцох хүүтэй бөгөөд хүүгийн хэмжээ нь мөн гэрээний 11.3 (д) хэсгийн (i) А-д зааснаар ХНГ хүчин төгөлдөр болсон 2009 оноос эхлэн 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны санхүүжилт жилийн 9.9 хувийн хүүтэй ажээ. Харин 2011 оны ХНГ-ээр 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойших хугацааны санхүүжилт нь улиралд LIBOR дээр нэмэх нь 6.50 гэсэн жилийн бодит хүүтэй болжээ. Өөрөөр хэлбэл, санхүүжилтийн хүү 2011 оны 1 дүгээр сарын 31-ээс хойш 9.9 хувиас LIBOR дээр нэмэх 6.50 болж буурчээ.

Мөн ХНГ-ний 11.3 (в)-д зааснаар “Хөврүүлэх өдрөөс өмнө үлдэгдэл төлбөрийн нийлбэр дүнг АНУ-ын хэрэглээний үнийн индексийн өмнөх улирлын өөрчлөлтөд нийцүүлэн өөрчилнө” гэжээ. Энэ заалтаар хөврүүлэх өдөр буюу 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс өмнөх буюу 2009-2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх үлдэгдэл төлбөрийн хэмжээг тогтоож байна. Үлдэгдэл төлбөр нь ХНГ-ний 11.3 (д)-ийн (ii)-т

зааснаар АйВиЭн-ийн санхүүжүүлэгчээс төлсөн нийт санхүүжилтийн дүн, хуримтлагдсан хүүгийн нийт дүнг үлдэгдэл төлбөр гэж томьёолон ХНГ-ийн 11.3 (е)-д зааснаар “Эрдэнэс МГЛ” болон Айвенхоугийн хувь нийлүүлэгчид жил бүр төлбөрийн тооцоог хамтран баталгаажуулж байна.

1.27 2009 оны болон 2011 оны ХНГ-д заасан үлдэгдэл төлбөрийг төлөх зохицуулалт анхаарал татаж байна. Эдгээр ХНГ-нд энэхүү үлдэгдэл төлбөрийг “Эрдэнэс МГЛ”-д ногдох ногдол ашгаас төлж барагдуулахаар заажээ. Өөрөөр хэлбэл, энэ төлбөрийг өөр бусад эх үүсвэрээс төлөхийг хориглосон заалт болжээ гэж үзэж байна. Ийм заалтыг гэрээнд оруулсан нь Монголын талыг өрийн дарамтад байлгах гадаадын хамтрагчийн зорилгыг дахин баталж байна. 2011 оны ХНГ-нд “Үлдэгдэл төлбөрийг буцаан төлөх” тухай заалтыг “Үлдэгдэл төлбөрийг бууруулах” гэж өөрчилсөн ч зарчим нь хэвээр үлджээ. Үлдэгдэл төлбөрийг ногдол ашгаас төлөх заалтыг 2011 оны ХНГ-ний 11.4 (а), (б), 15.1 болон 15.2 (а), (б), (в)-д тус тус баталгаажуулан заажээ.

Эдгээр заалтуудаас анхаарал татаж байгаа заалт нь 11.4 (б)-д заасан “ТӨК нь ... үлдэгдэл төлбөрийн эргүүлж төлж дуусах хүртэл өөрт ногдох ногдол ашгийг бүхэлд нь АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн хувь нийлүүлэгчээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) шууд төлөхийг Компанид энэхүү гэрээгээр эргэлт буцалтгүйгээр чиглэл болгож байна” гэсэн заалт, ХНГ-ний 15.2 (б) “Компани нь энэхүү гэрээний 15.2 (а) (i)-д заасны дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид үлдэгдэл төлбөр төлөх нь ТӨК-д ногдол ашиг төлөх үүргээ биелүүлж байгаатай ижил гэж тооцогдоно” гэсэн заалт, мөн 15.2 (в) “Талууд өөрөөр тохироогүй бол ...ТӨК нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.8-д заасан өөрт ногдох ногдол ашгаа дайчлах эрхээ эдлэхгүй” гэсэн заалтууд анхаарал татаж байна. Эдгээр заалтуудаар бол Монгол тал ирээдүйд авах ногдол ашгаа (хэрэв ногдол ашиг авбал) өр төлөхөд зориулахаар байна.

Иймд гэрээний үндсэн хугацаа 30 жил, хоёр удаа тус бүр 20 жилээр сунгах 40 жил, нийт 70 жилийн санхүүжилтийн дүнгээс Монголын талын 34 хувьд хувь тэнцүүлэн тооцож, өрийн дүнг тооцож гаргах шаардлагатай. Ирээдүйд үүсэх энэ өрийг Монголын тал ногдол ашгаас төлөөд ашигтай үлдэх үү гэдэг нь энэ ордыг ашиглах ач холбогдлыг тодорхойлох болно.

1.28 2009 оны ХНГ-ний 11.1-д зааснаар Компанийг санхүүжилтийн нэг арга нь санхүүжүүлэх хувьцаа гаргах арга ажээ.

2009 оны ХНГ-ийн 11.1 (а)-д зааснаар энэ аргаар санхүүжилт хийхэд “Эрдэнэс МГЛ” оролцохгүй, тийм үүрэг хүлээхгүй бөгөөд зөвхөн АйВиЭн, ОТН, эсхүл тэдгээрийн томилсон этгээд болох “Рио Тинто Групп”, “Айвенхоу Групп”-ийн аливаа гишүүн хамаарахаар заажээ. Энэ нь хэдийгээр Монголын тал мөнгөн хөрөнгө гаргахгүй байх давуу байдал олгож байгаа мэт боловч гадаадын хамтрагч талд ашигтай. Учир нь ХНГ-ийн 11.3 (а)-д зааснаар санхүүжүүлэх хувьцаанд улирал тутам ногдол ашиг төлж байна.

Энэ аргыг ХНГ-ний 11.1-д санхүүжүүлэх хугацаанд (буюу энэ гэрээ хүчин төгөлдөр болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 жилийн хугацааны санхүүжилтийг хангахад) хэрэглэхээр зааснаас харахад энэ дагуу санхүүжилт хийгдэж, санхүүжүүлэгч ногдол ашиг авсан байна. Энэ заалтаар 2009-2011 он хүртэл санхүүжүүлэх хувьцаа гаргасан эсэх, гаргасан бол түүнд төлсөн хүүгийн хэмжээ хэд болохыг тогтоох шаардлагатай. 2011 оны ХНГ-ний зохицуулалтаас харахад энэ хэлбэрээр санхүүжилт хийгдэж, ногдол ашиг төлсөн байна гэж үзлээ.

Харин 2011 оны ХНГ-ээр энэ хувьцааг хөрвүүлэхээр зааж, 2011 оны ХНГ-ний 12-т шинээр зохицуулалт хийсэн байна. Гэрээний энэ зүйлд зааснаар 2011 оны 1 дүгээр

сарын 31-ний өдрөөс хойш өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээний 11.1-д заасны дагуу гаргасан төлөгдөөгүй бүх санхүүжүүлэх хувьцааг хувьцаанд хөрвүүлжээ. Ийнхүү хувьцаанд хөрвүүлэхдээ (i) Компани хөрвүүлэх тухайн өдрийн байдлаарх санхүүжүүлэх хувьцаа тус бүрийн нэрлэсэн үнэ болон эдгээр тус бүрийн санхүүжүүлэх хувьцаа тус бүрийн төлөгдөөгүй болон хуримтлагдсан ногдол ашгийн үнийн нийлбэр (хамтад нь *хөрвүүлэх дүн* гэх)- тэй тэнцэх тооны хувьцаа гаргана. (ii) Ийм хувьцааг хувь нийлүүлэгч тус бүрд тэдгээрийн холбогдох эзэмшлийн хувь хэмжээнд хувь тэнцүүлэн олгоно, (iii) хөрвүүлэх дүнгийн 34 хувийг санхүүжүүлсэн дүн гэж үзэх бөгөөд үлдэгдэл төлбөрийн дүн нэмж тооцно. (ийм санхүүжүүлсэн дүнгийн хувьд энэхүү гэрээний 11.1(г)-д заасны дагуу зээлийн гэрчилгээ олгоно) гэж заажээ.

Ингэснээр 2009 оны ХНГ-д байсан давуу эрхийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийх 11 дүгээр заалт бүхэлдээ хүчингүй болж, энэ санхүүжилт нь компанийн хувьцаа болж хувирчээ. Монголын талын эзэмшлийн хувьцааны хувь хэмжээ буураагүй, өөрийн эзэмшлийн 34 хувьдаа хувь тэнцүүлэн хувьцаа авсан хэдий ч энэ нь хөрөнгө оруулагч талын санхүүжилт гэж үлдэгдэл төлбөрт нэмж тооцогдож байна. Өөрөөр хэлбэл, зээлийн санхүүжилт болж, уг санхүүжилтийн хувьцааг хувьцаанд хөрвүүлснээр Монголын талын 34 хувьд ногдох өр нэмэгдэж, үлдэгдэл төлбөрийн дүнд нэмж тооцогджээ.

Энэ хөрвүүлсэн дүнгийн хэмжээ болон энэхүү санхүүжүүлэх хувьцаанд төлсөн ногдол ашгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай.

1.29 2009 оны ХНГ-ний 12 дугаар зүйл нь АйБиЭн-ийн санхүүжүүлэгчээс өрийн санхүүжилт хийх тухай зохицуулсан байна. Энэ зүйлд зааснаар санхүүжилтийн хугацаанд (буюу энэ гэрээ хүчин төгөлдөр болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 жилийн хугацааны санхүүжилтийг хангахад) санхүүжилтийг хувь нийлүүлэгчдээс олгох өрийн хэлбэрээр нийлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд АйБиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэх ёстой гэж заажээ.

Энэхүү санхүүжилт нь улирал тутам төлөх хүүтэй байна. Энэ заалтаас харахад санхүүжилтийг хийх шийдвэрийг Айвенхоугийн хувь нийлүүлэгчид дангаараа бие даан гаргаж байна. Санхүүжилттэй холбоотой бүхий л шийдвэрийг гаргах, хэнээс санхүүжилт авах зэргийг зөвхөн өөрт хамааралтай этгээдүүдтэй холбож ХНГ-нд олон удаа байнга давтан зааж баталгаажуулжээ.

Энэ заалтыг 2011 оны ХНГ-ээр “Хувь нийлүүлэгчийн зээл” болгон өөрчилсөн байна. 2011 оны ХНГ-ний Хувь нийлүүлэгчийн зээл гэсэн 13.1-д зааснаар (а) Айвенхоугийн хувь нийлүүлэгчид (Санхүүжилтийн хугацааны туршид), эсхүл ТУЗ (санхүүжилтийн хугацаа дууссаны дараа) нь Хувь нийлүүлэгчдийн авах зээлийн хэлбэрээр санхүүжилт хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэх шийдвэр гаргаж болно (гэвч ингэх үүрэг хүлээхгүй). ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Компани болон Айвенхоугийн хувь нийлүүлэгчдэд бичгээр (Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлт ирснээс хойш 5 (таван) ажлын өдрийн дотор) урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв энэ хугацаанд ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхгүй байх шийдвэр гаргасан ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэнд тооцогдоно. Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа Айвенхоугийн хувь нийлүүлэгчид өөрийн эзэмшлийн хувь хэмжээнд ногдох шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд Компани болон ТӨК-д бичгээр (шаардсан мөнгөн нийлүүлэх хүсэлт ирснээс хойш 5 (таван) ажлын өдрийн дотор)

урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв Айвенхоугийн хувь нийлүүлэгчид энэ хугацаанд ийм шийдвэр гаргаагүй бол энэхүү гэрээний 10.2 (а)-д заасны дагуу түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхээр шийдвэрлэсэнд тооцогдоно. Мөн (б) санхүүжилтийн хугацааны туршид хэрэв ТӨК түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг хувь нийлүүлэгчдийн зээл хэлбэрээр нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (эсхүл шийдвэрлэсэн гэж тооцогдох) бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгч энэхүү гэрээний 13-т заасны дагуу ТӨК-ийн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэсгийг санхүүжүүлэх үүрэгтэй” гэж, мөн (в)-д санхүүжилтийн хугацаа дууссаны дараа хэрэв ТӨК 5 (таван) ажлын өдрийн дотор түүнээс шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (эсхүл шийдвэрлэсэн гэж тооцогдох) бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгч энэхүү гэрээний 13-т заасны дагуу ТӨК-ийн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэсгийг ажлын дараагийн 5(таван) өдрийн Хувь нийлүүлэгчийн зээл хэлбэрээр санхүүжүүлэхээр шийдвэрлэж болно. (гэхдээ ийм үүрэг хүлээхгүй) гэж зааснаар “Эрдэнэс МГЛ” компани “Оюу толгой” төслийг санхүүжүүлэх санхүүжилтийн хугацаа болон санхүүжилтийн дараагийн хугацаанд өөрөө санхүүжилт хийх шийдвэр гаргах боломж олгосон байх хэдий ч энэхүү боломжийг Монголын тал ашиглаагүй байна. Тиймээс энэ гэрээнд зааснаар АйВиЭн-ийн санхүүжүүлэгч зээлээр санхүүжүүлж байна.

Зээлийн хүүг гэрээний 13.1(г)-д хүүг хувь нийлүүлэгчдийн зээл болон аливаа хуримтлагдсан хүүгийн нийлбэр дээр тооцох бөгөөд улирал тутамд хуримтлуулан дараах байдлаар тооцож байна. (i) Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн хөрвүүлэх өдрийн өмнөх өдөр хүртэлх хугацааны хувь хуанлийн улирал тутамд АНУ-ын хэрэглээний үнийн индексээр тохируулсан санхүүжилтийн улирал тутмын хүү, (ii) хөрвүүлэх өдөр болон түүнээс хойших хугацааны хувьд хуанлийн улиралд LIBOR дээр нэмэх нь 6.50 хувь байна.

Санхүүжилт зээл гэдгийг 2011 оны ХНГ-ийн 13.1 (д)-д “...Хувь нийлүүлэгчдийн зээлийн нөхцөл, болзлыг тодорхойлсон зээлийн гэрээг Компани болон хувь нийлүүлэгчдийн хооронд шуурхай байгуулна” гэсэн заалт баталж байна.

2011 оны ХНГ-ний 13.2-т зааснаар хувь нийлүүлэгчдийн зээлийг тэргүүн ээлжид төлнө. Өөрөөр хэлбэл, Компани (энгийн хувьцаанд) ногдол ашиг хуваарилахаас өмнө хувь нийлүүлэгчийн зээлийг энэхүү гэрээний 15.1 (г)-д заасны дагуу буцаан төлнө. ХНГ-ийн 15.1 дэх заалт нь ногдол ашиг төлөх тухай заалтаар баталгаажиг байна.

Дээрх зохицуулалт нь давуу эрхийн хувьцаа гаргаж санхүүжүүлэх гэдэг хэлбэрээс хувь нийлүүлэгчийн зээл хэлбэрт шилжсэн ч тэргүүн ээлжид санхүүжилтээ хүүгийн хамт буцаан авах зохицуулалтаа хэвээр хадгалжээ. Өмнө нь зөвхөн давуу эрхийн хувьцаа гаргах гэдэг хэлбэрийг зээл гэдэг хэлбэрт оруулж, төлбөрөө давуу эрхээр авах давуу байдлыг хэвээр хадгалж байна. Зөвхөн нэг хэлбэрийн санхүүжилтэд хадгалагдаж байсан давуу байдлыг ердийн зээлийн санхүүжилтэд ашиглахаар тусгажээ.

1.30 2009 оны ХНГ-ний 13 дугаар зүйлд төслийн санхүүжилтийг гуравдагч этгээд буюу олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн банк санхүүгийн байгууллагаас авахаар заасан байна. Энэ шийдвэрийг компанийн ТУЗ гаргана. Компанийн хувь нийлүүлэгчид зохих дэмжлэгийг үзүүлэхээр тохирчээ.

Компанид буюу “Оюу толгой” компанид шаардлагатай шаардсан мөнгөн хөрөнгийг олж нийлүүлэх зохицуулалтыг гэрээнд тусгахдаа үндсэн хоёр хэсэгт хуваажээ. Нэгдүгээрт, санхүүжилтийн хугацаанд (энэ гэрээ хүчин төгөлдөр болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 жил өнгөрөх хүртэлх хугацаа)

хоёрдугаарт, санхүүжилтийн хугацааны дараах үе (санхүүжилтийн хугацааны 3 жил дууссаны дараагаас төсөл дуусах хүртэлх хугацаа).

Энэ бүх хугацааны санхүүжилтийг (1) энгийн хувьцаа гаргах, (2) санхүүжүүлэх хувьцаа гаргах, (3) өрийн санхүүжилт хийх, (4) олон улсын санхүүгийн байгууллагаас санхүүжүүлэх гэсэн аргуудаар хэрэглэхээр заажээ. Санхүүжилтийн 4-д заасан аргаас бусад бүх тохиолдолд санхүүжилтийг Айвенохоугийн хувь нийлүүлэгчид болон “Рио Тинто групп” түүний хамааралтай этгээдүүд бүрэн бие дааж өөрийн үзэмжээр удирдахаар гэрээгээр баталгаажуулжээ. Бүх санхүүжилт нь Компанид өр үүсгэж байгаа бөгөөд улирал бүр хүү төлж байна. Мөн Санхүүжүүлэх хувьцаанд улирал бүр ногдол ашиг төлж байна.

Монголын тал санхүүжилтийн үүрэг хүлээхгүй хэмээн заасан нь давуу байдал харагдаж байгаа хэдий ч санхүүгийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байхаар зохицуулж, санхүүжилтийн төлбөрт Монголын талын нэр дээр өр бичигдэж, улирал бүр зээлийн хүү төлж, өрийн дарамтад орж байна. Тэгээд ч санхүүжилтийн дүнгээс төлөөгүй үлдсэн буюу хуримтлагдсан үлдэгдэл төлбөрийг ирээдүйд өөрт ногдох ногдол ашгаас төлөхөөр тохирчээ.

Санхүүжилттэй холбоотой аливаа шийдвэрийн Айвенохоугийн хувь нийлүүлэгч, АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид гаргаж, Монголын тал түүнийг нь заавал дэмжих үүрэг хүлээсэн байна. 2009 оны ХНГ-ний энэ зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явагдсан тул энэ заалтын дагуу явагдсан үйл ажиллагааг шалган Монголын талын эрх ашиг сонирхолд учирсан эерэг, сөрөг талыг тооцон үзэх нь зүйтэй.

2009 оны ХНГ-ний энэ зохицуулалт 2011 оны ХНГ-д дараах байдлаар өөрчлөгджээ. Үүнд:

Төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авахдаа гэрээний 14 (а)-д заасан ТУЗ-ийн эрх мэдлийг хязгаарлахгүйгээр (i) хэрэв ОТ төслийн хувьд үр өгөөжтэй, зохистой байвал төслийн санхүүжилтийг Компанийг санхүүжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой механизм болгож ашиглах, (ii) ОТ мэт төсөлд зориулан олон улсын банкны зах зээлээс төслийн санхүүжилт олгодог хамгийн сайн нөхцөлөөр ийм төслийн санхүүжилтийг боломжтой хурдан хугацаанд авахад нь Компанид туслах зэргээр боломжтой хүчин чармайлтыг дайчлахаар Хувь нийлүүлэгчид харилцан тохиролцжээ.

2009 оны ХНГ-ны зохицуулалт үүргээ гүйцэтгэсэн учраас 2011 онд үүнийг өөрчилсөн гэж дүгнэж байна. 2009 оноос хойш санхүүжилтийн хугацааны 3 жил өнгөрч, цаашид энэ аргыг гадаадын хөрөнгө оруулагч хэрэглэхгүй болсон учир өөрчилсөн гэж үзэж байна. Тиймээс 2009 оны ХНГ-ээр 2011 он хүртэл санхүүжилт хаанаас авсан болох, түүний үр өгөөжийг сайтар судалж үзэх шаардлагатай.

Мөн энэ гэрээний 14 дүгээр зүйлийн (в)-д Компанид зориулан аливаа хувь нийлүүлэгч, эсхүл АйВиЭн-ийн санхүүжүүлэгч “Оюу толгой” төсөлд зориулан гуравдагч талын төслийн санхүүжилтийн хэлбэрээр авсан хөрөнгийн бүрэн хэмжээний өртөг зардал дээр татварын шаардлагыг харгалзан хураамж ногдуулах, эсхүл аливаа ашиг буюу нэмэлтийг дамжуулахгүй байхыг хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрч байна” гэдэг заалтыг тодруулан тайлбарлах шаардлагатай. Энэ заалтаар гуравдагч талаас авсан санхүүжилт дээр гадаадын хамтрагч тал татварын шаардлагаар хураамж ногдуулахгүй, аливаа ашиг нэмэхгүй байхаар тохирчээ гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, гуравдагч этгээдээс авч байгаа санхүүжилт дээр гадаадын хөрөнгө оруулагч тал хувь хэмжээ нэмэхгүй гэж тохирсон тохиролцоо гэж үзэх болох эсэхийг баталгаажуулах ёстой.

1.31 Дэлхийн алт зэсийн том орд болох Оюу толгойн ордыг ашиглах талаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хамтран ажиллах гол сонирхол, нөхцөл нь уг ордын баялгаас ашиг хүртэх явдал юм. Энэ зорилгоор ногдол ашиг авахтай холбоотой заалт нь гэрээний хамгийн гол зүйл, Монголын талын ашиг сонирхол юм.

Ногдол ашигтай холбоотой заалтыг 2009 оны ХНГ-ний 14 дүгээр зүйлд тусгасан байна. Гэрээнд ногдол ашиг хуваарилахтай холбоотой 2 зүйл, 7 хэсэг, 7 заалт байна. Эдгээрт заахдаа Компани нь тухайн жилд ашигтай ажилласан бол ТУЗ нь ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргана, ингэхдээ Компанид 5 үүрэг хүлээлгэж, түүнийг дэс дараалан биелүүлээгүй тохиолдолд ногдол ашиг хуваарилахгүй ажээ. Эдгээр нь өмнө авсан бүх төрлийн санхүүжилт, өр, зээл, түүний хүү, давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашгийг төлсөн байх нөхцөлүүд байна. Энэ заалтын баталгаажуулж ХНГ-ийн 15.5 (б) хэсгийн (iii) заалтын В)-ийн 2-т “ТӨК-д төлөх ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон Айвенхоугийн санхүүжүүлэгч авсны дараа нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрөв” гэсэн байна. Эдгээр төлбөрийг төлөөд Компанид үлдэх ашиг байх уу гэдэг нь Монголын талын анхаарах асуудал юм.

Монголын талаас үл хамаарч шийдвэр гаргах эрхтэй болохын хувьд гадаадын хамтрагч, хувь нийлүүлэгч талын хамааралтай санхүүжүүлэгч нарын авсан хүүтэй зээлийн санхүүжилт, бусад төлбөрийг төлж дуусахад Компани өртэй үлдэх зориуд, санаатай зохион байгуулсан санхүүгийн схем бүтэц зохиожээ гэдэг хардлага төрүүлж байна.

2011 оны ХНГ-нд ногдол ашиг төлөхтэй холбоотой дараах заалтуудыг зөвхөн гэрээний зүйл, заалтын дугаарлалт, нэр томъёо өөрчлөгдсөнтэй холбоотой өөрчлөлтийг тусгасан байна. Зарчмын хувьд өөрчлөлт ороогүй. Тухайлбал, өмнөх 2009 онд ХНГ-нд гуравдагч этгээдийн зээл гэснийг 2011 оны ХНГ-ний 15.1 (г) заалтын (i)-д гуравдагч этгээдийн Төслийн санхүүжилт гэж, мөн зүйлийн (iii)-д энэхүү гэрээний 13-т заасан хувь нийлүүлэгчийн өрд тооцох аливаа хүү болон санхүүжүүлэх хувьцаанд (тэдгээрийн энэхүү гэрээний 12-т заасны дагуу хувьцаанд хөрвүүлээгүй бол) ногдох бүх ногдол ашгийг Компани бүрэн төлсөн байх (дараалал нь нэг байна), мөн зүйлийн (iv)-т энэхүү гэрээний 13-т заасан хувь нийлүүлэгчийн өрийн бүх үндсэн өрийг Компани бүрэн буцаан төлсөн байх болон бүх санхүүжүүлэх хувьцаа (тэдгээрийн энэхүү гэрээний 12-т заасны дагуу хувьцаанд хөрвүүлээгүй бол)-ны хөрөнгийг Компани эргүүлэн авсан байх (дараалал нь нэг байна) гэж хувьцааг хөрвүүлэхтэй холбоотой тодотгол орсон орж, 2009 оны ХНГ-ний бусад заалтууд хэвээр үлдсэн байна.

2009 оны ХНГ-ийн 14.2(б)-д “Компани энэхүү гэрээний 14(а), (i)-д заасны дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид үлдэгдэл төлбөр төлөх нь ТӨК-д ногдол ашиг төлөх үүргээ биелүүлж байгаатай ижилд тооцогдоно” гэж зааж өрийн төлбөрийг ногдол ашигт тооцно хэмээн төөрөгдөл үүсгэж байна.

Ингэснээр төслөөс Монголын тал ногдол ашиг авсан мэтээр тохиролцоо хийжээ. Ногдол ашиг нь аливаа өр, төлбөрийн дараа үлдсэн цэвэр ашиг байдаг атал Компани үйл ажиллагааны санхүүжилтэд аваад Компаниас төлөх үлдэгдэл төлбөрийг зөвхөн нэг Хувь нийлүүлэгч болох Монголын талын ногдол ашиг байсан мэтээр заасан нь шударга бус, тэнцвэргүй, эрх тэгш бус хамтын ажиллагаа гэж дүгнэж байна. Тэр тусмаа ХНГ-ийн 14.2(в) заалтаар “...ТӨК нь аж ахуйн орлогын албан татварын тухай хуулийн 21.8-д заасан өөрт ногдох ногдол ашгаа дайчлах эрхээ хэрэгжүүлэхгүй” гэсэн үүрэг авсан нь хууль бус гэж үзэж байна. Хууль хэрэгжүүлэхгүй байх үүргийг гэрээгээр хүлээж болохгүй. Тэр тусмаа Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж, хангах” үүрэг хүлээсэн Засгийн газар нь гадаад улсын компанийн өмнө хууль хэрэгжүүлэхгүй байх

үүрэг хүлээсэн нь хууль зөрчсөн үйлдэл юм. 2009 оны ХНГ-ний эдгээр заалтуудыг 2011 оны ХНГ-ний 15.2 болон хэвээрээ үлдсэн.

1.32 2011 оны ХНГ-ний 16.1 болон 16.2-т зааснаар хувь нийлүүлэгчид нь бусад хувь нийлүүлэгчдийн зөвшөөрлийг бичгээр авч өөрийн эзэмшлийн хувьцаагаа хэсэглэн, эсхүл бүхэлд нь гуравдагч этгээдэд шилжүүлж болно. Гэхдээ бусад хувь нийлүүлэгчдээ тэргүүн ээлжид санал болгохоор тусгажээ. Ажлын 50 өдрийн дотор хариу өгөхгүй бол сонгогдсон гуравдагч этгээдэд мөн ижил нөхцөлөөр шилжүүлэхээр заажээ.

2011 оны ХНГ-ний 16.3-т “Зөвшөөрөгдсөн шилжүүлэг” гэдэг заалтаар “Айвенхоу групп”, “Рио Тинто групп”-ийн аливаа гишүүн нь өөрийн группийн аливаа гишүүнд энэ гэрээний шаардлагыг хангахгүйгээр өөрийн эзэмшлийн хувьцааг бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлэх эрхтэй байна. “Эрдэнэс МГЛ” өөрийн эзэмшлийн хувьцаагаа 100 хувь төрийн хяналтад шилжүүлэхэд мөн энэ эрхийг эдэлнэ.

Харин Монгол Улс өөрийн эзэмшлийн хувьцааны 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр худалдахад хязгаарлалт тогтоогоогүй байна. Монгол Улс өнөөдрийг хүртэл энэ боломжийг ашиглаагүй байна.

1.33 2011 оны ХНГ-ийн 16.4-д хувь нийлүүлэгч өөрийн эзэмшлийн хувьцааг барьцаалах тухай зохицуулсан байх боловч мөн гэрээний 16.5-д заасан шаардлагуудыг хангаж байж тэрхүү эрхээ хэрэгжүүлэх боломжтой. Гэвч Монголын тал гэрээний шаардлагыг хангах боломжгүй байна. Тухайлбал, ХНГ-ийн 16.5 (б) хэсгийн (iii) заалтын В)-ийн 2 “ТӨК-д төлөх ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон АйВиЭн-ийн санхүүжүүлэгч авсны дараа нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрөв” гэсэн болон ХНГ-ийн 16.5 (в) хэсгийн (iii)-т тус тус заасан “ТӨК-д төлөх ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон Айвенхоугийн санхүүжүүлэгч тэргүүн ээлжид авах эрхээ эдэлсний дараа зөвшөөрөгдсөн барьцаалагчийн эрх нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрөв” гэсэн шаардлага хангагдах нь бэрхшээлтэй.

Харин 2011 оны ХНГ-ний 16.5 (а) заалтыг ашиглан Монголын тал өөрийн эзэмшлийн 34 хувийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагад барьцаалан зээл авах боломж байгаа мэт боловч ийнхүү зээл авах асуудлыг ТУЗ шийдвэрлэж байгаа нь хүндрэл учруулна. Учир нь Монголын тал ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлөх саналыг эрхгүй. Энэ эрхийг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар болон “Эрдэнэс МГЛ” ямар нэгэн үйл ажиллагаа өнөөдрийг хүртэл хийгээгүй байна.

1.34 2009 оны болон нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон ХНГ-ээс харахад “Оюу толгой” төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой Монголын талд үүрэг хүлээлгэсэн, эрхийг нь хязгаарласан, аливаа эрхээ хэрэгжүүлэхэд нь биелэгдэх боломжгүй нөхцөл болзол тавьсан заалтууд олон байна.

Цөөн хэдэн боломж байгаагийн нэг нь ХНГ-ийн 16.6-д зааснаар төр нь өөрийн эзэмшлийн хувьцаагаа Монголын хөрөнгийн бирж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийг биржид арилжиж болох эрхтэй.

1.35 2009 оны ХНГ-ний 15.10 болон 2011 оны ХНГ-ний 16.10-д Монголын тал Компани дахь хувь эзэмшлээ 16 хувиар нэмэгдүүлж 50 хувь болохтой холбоотой зохицуулалтыг тусгажээ. Гэхдээ Хөрөнгө оруулалтын гэрээг анх удаа сунгасан өдрөөс хойш 1 жилийн дотор гэдэг нөхцөл заажээ.

Энэхүү нөхцөлөөр Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн хугацаа 30 жил дээр анх удаагийн сунгалтын 20 жилийг нэмж, нийт 50 жилийн дараа буюу 2059 онд Монголын

талд энэхүү эрх үүснэ. Ингэхдээ “Эрдэнэс МГЛ” болон Айвенхоугийн хувь нийлүүлэгчид харилцан тохиролцсон нөхцөлөөр хэрэгжүүлнэ гэж ХНГ-ийн 16.10 (а)-д заажээ. Харилцан зөвшөөрсөн нөхцөл нь ямар байх тухай гэрээнд огт заагаагүй учир Айвенхоугийн хувь нийлүүлэгчид хүлээн авах боломжгүй аливаа нөхцөл тавих хэлбэрээр харилцан зөвшөөрөхгүй байхад энэ эрх хэрэгжихгүй.

Тэгээд ч энэ тохиролцоо нь УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолын хавсралт Оюу толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамжийн 2 дахь хэсгийн 1-д заасан “Монголын талын эзэмшлийг 34 хувиас эхэлж, анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа 50 хувь болгох асуудлыг гэрээнд тусгах хувилбар”-ыг шууд зөрчсөн байна.

2011 оны гэрээний 16.10 (г)-д зааснаар Монголын тал 50 хувь болсон “Оюу толгой” төслийг удирдах эрх мэдэл нэмэгдэхгүй, харин ч Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь “Оюу толгой” төслийн менежментийн эрхийг бүрэн хэмжээгээр хязгаарлалтгүй хадгалж байна. Мөн Хувь нийлүүлэгчийн болон ТУЗ-ийн бүх хуралд шийдвэрлэх саналын эрхтэй байна гэжээ. Үүнээс харахад 2009 онд Монголын тал хувьцааны 50 хувийг эзэмших болсон ч шийдвэр гаргах эрх болон “Оюу толгой” компанийн санхүү, менежмент, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдах эрх шилжихгүй, 34 хувьтай байх үеэс өөрчлөгдөхгүй ажээ. Өөрөөр хэлбэл, Монголын тал 50 хувийн хувьцаа эзэмших эрхтэй болсон ч холбогдох гэрээнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй, харин гэрээний 15.10 (г)-д заасан Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь “Оюу толгой” төслийн менежментийн эрхийг бүрэн хэмжээгээр хязгаарлалтгүй эдлэхийг баталгаажуулж, Хувь нийлүүлэгчийн гэрээ болон компанийн бусад баримт бичигт шаардлагатай өөрчлөлтийг хийхээр тохирчээ. Айвенхоугийн тал бүрэн эрхээ хадгалж үлдэж байна.

1.36 Гэрээний үйлчлэл, түүнийг дагаж мөрдөх зохицуулалтыг 2009 оны ХНГ-ний 18 болон 2011 оны ХНГ-ний 19-д заасан бөгөөд энэхүү гэрээ нь Компанийн дүрмийн заалттай зөрчилдвөл гэрээний заалтыг баримтлах давуу эрхтэй байна. Иймд Компанийн дүрмээр Хувь нийлүүлэгч болон ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд тусгайлан эрх олгосон заалт тусгасан ч ХНГ-тэй зөрчилдвөл түүнийг дагаж мөрдөхгүй байхаар зохицуулжээ. Монгол Улсын Компанийн тухай хуульд зааснаар Компанийн дүрэмд өөрөөр зааж болох зохицуулалтыг зөвшөөрсөн байдаг. Хувь нийлүүлэгчийн гэрээнд өөрөөр заасан нь дүрмээс давуу үйлчлэх тухай зохицуулалт Компанийн тухай хуульд байхгүй байна.

1.34 2009 оны ХНГ-ний 23.3 болон 2011 оны ХНГ-ний 24.2-т “Хувь нийлүүлэгч болон түүний хамаарал бүхий компани (аль холбогдох нь) авлигатай тэмцэх талаарх өөрийн үүсгэн байгуулагдсан улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх бөгөөд Монгол Улсад явуулах үйл ажиллагаагаа эдгээр хуулийн хүрээнд явуулна” гэж заасан нь авлигаас ангид байх чухал заалт болжээ. Манай хууль хяналтын байгууллагууд, ялангуяа АТГ энэ заалтын дагуу үйл ажиллагаа явуулах боломжтой.

Оюу толгойн ордыг ашиглах Хувь нийлүүлэгчийн гэрээнүүдийг (2009 болон 2011 он) судалж үзээд дараах Санал, дүгнэлтийг танилцуулж байна.

ХОЁР. ДҮГНЭЛТ

1. Оюу толгойн ордыг ашиглах Хувь нийлүүлэгчийн гэрээ байгуулсан нэг оролцогч тал болох “Айвенхоу Оюу Толгой” (БиВиАй) Лтд нь оффшор бүс болох Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй компани байх бол, нөгөө нэг тал болох “Оюу Толгой Нидерланд БиВи” компани нь Нидерланд Улсад бүртгэлтэй компани байна. Оюу Толгой төслийг ашиглах гадаадын хамтрагч, Монгол Улсад

шууд хөрөнгө оруулагч нь Британийн Виржинийн Арлууд болон Нидерланд улсын хуулийн этгээдүүд байна. Эдгээр хөрөнгө оруулагчдын оффшор бүс дэх бүртгэл өөрчлөгдсөн үү гэдэг нь тодорхойгүй байна.

2. 2009 оны болон 2011 оны ХНГ-нд “Эрдэнэс МГЛ” компани өөрөө зөвшөөрснөөр “Оюу толгой” компанид эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээг бууруулж болох боломжийг Хөрөнгө оруулагч талтай тохиролцсон байна. ХНГ-нд “Одоогийн бүх хувь нийлүүлэгчид энэ гэрээний 4-т заасны дагуу төрийн эзэмшлийн хувьцааны хувьд хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхыг зөвшөөрч байна” гэж заасан нь одоогийн хувь нийлүүлэгч гэсэн тодотголтой байгааг анхаарах нь зүйтэй. Хэрэв одоогийн буюу гэрээ байгуулсан үеийн хувь нийлүүлэгч нь ирээдүйд өөрчлөгдвөл энэхүү заалт тэрхүү шинэ хувь нийлүүлэгчид хамаарахгүй байхаар байна.

Түүнчлэн ХНГ-нд одоогийн хувь нийлүүлэгчид өөрийн эзэмшлийн хувьцааг бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлэх боломжтой зохицуулалтыг тусгажээ. Хэдийгээр хувь нийлүүлэгч шилжүүлэхдээ бусад хувь нийлүүлэгчид тэргүүн ээлжид санал болгох заалт байгаа ч Монголын тал хувьцааг худалдан авах санхүүгийн боломжгүй бол хувьцаа гуравдагч этгээдэд шилжиж, Компанид шинэ Хувь нийлүүлэгч орж ирнэ. Жишээ нь, хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийн өөрийн эзэмшлийн 49 хувийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авахыг санал болгосон ОХУ-ын Засгийн газрын саналаас Монгол Улсын Засгийн газар татгалзаж байсан үйлдэл ирээдүйд давтагдахыг үгүйсгэхгүй.

3. “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн 9 гишүүний 6 нь буюу дийлэнх олонх нь гадаадын хөрөнгө оруулагч талаас байна. ТУЗ-ийн хурлын ирц ТУЗ-ийн нийт гишүүдийн дийлэнх олонхоор буюу 6 гишүүнээр бүрдэхээр заажээ. Мөн энэ заалтад ТУЗ-ийн 6 гишүүний ирцийг бүрдүүлэхдээ хөрөнгө оруулагч талын 4 гишүүн дээр нэмэгдэж, Айвенхоугийн хувь нийлүүлэгч 1 гишүүн болон Монголын талаас томилсон ТУЗ-ийн 1 гишүүн заавал оролцсон байх шаардлага тусгажээ. Үүнээс харахад ТУЗ-ийн Монголын талын 3 гишүүнээс 1 гишүүн нь хуралд оролцоод байхад ирц бүрдүүлэх энэ шаардлага хангагдаж байна.
4. “Оюу толгой” компанийн ТУЗ дээр асуудал шийдвэрлэх өөр нэг боломжийг Хөрөнгө оруулагч тал эдэлж байна. Хөрөнгө оруулагч тал өөрсдийн томилсон ТУЗ-ийн гишүүдийн дундаас ТУЗ-ийн даргыг томилох бөгөөд мөн гэрээнд зааснаар аливаа асуудлаар ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцвэл ТУЗ-ийн дарга тухайн асуудлыг эцэслэн шийдвэрлэх саналын эрхтэй байхаар заажээ. ТУЗ-ийн даргад эрх олгосон энэ зохицуулалт Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулсан 2014 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсон.
5. 2009 оны болон 2011 оны ХНГ нь “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн Монголын талын 3 гишүүн ТУЗ-ийн хурлын ирц болон аливаа шийдвэрт ямар ч нөлөө үзүүлэхгүй байхаар байгуулагджээ. “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн шийдвэрийг тухайн хуралд оролцож байгаа саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн дэмжсэн саналаар гаргана гэж зааснаас дүгнэхэд ТУЗ-д байгаа Монгол талын 3 гишүүн ямар ч тохиолдолд “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлөх боломжгүй, билэг тэмдэг төдий үүрэг гүйцэтгэж байна.

ТУЗ-ийн Монголын талын 3 гишүүн хэлэлцсэн асуудлаар эсрэг санал өгсөн ч Хөрөнгө оруулагч талын 6 гишүүн дийлэнх олонхоор асуудлыг шийдвэрлэнэ. Мөн Монголын талын гишүүд ТУЗ-ийн хурлын ирц бүрдүүлэхгүй байх

боломжгүй. Монголын талын 3 гишүүн ТУЗ-ийн хуралд очихгүй бол ТУЗ-ийн хурал хойшилно. ТУЗ-ийн хойшилсон хурлын ирц ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх буюу Хөрөнгө оруулагч талын 6 гишүүн хүрэлцэн ирснээр бүрдэж, тэрхүү 6 гишүүний дийлэнх олонх буюу 5 гишүүний саналаар ТУЗ-ийн хурлын шийдвэр батлагдана. Монголын талын 3 гишүүн ТУЗ-ийн аливаа шийдвэрт нөлөөлөх, Монгол Улсын эрх ашгийг хамгаалсан шийдвэрийг батлуулах боломжгүй.

Учир нь “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн хойшлогдсон хурлын ирцэд Монголын талын 1 гишүүн заавал оролцож байж ирц бүрдэх тухай тусгайлсан шаардлага байхгүй. ТУЗ-ийн нийт гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэр гаргах аливаа асуудлыг ХНГ-ээр тохироогүй, Хөрөнгө оруулагч талд давуу байдал олгожээ. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80.6-д зааснаар ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэх асуудалд тусгайлан өндөр хувь тогтоох зохицуулалтыг компанийн дүрэмд тусгах боломжтой. Гэтэл “ХНГ нь Компанийн дүрмээс давуу байх”-аар гэрээнд тусгаж, Монголын тал ТУЗ дээр шийдвэр гаргахад нөлөөлөх боломжтой Компанийн тухай хуулийн дээрх заалтыг ашиглахгүй байхаар баталгаажуулсан байна.

6. “Оюу толгой” компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаар асуудлыг шийдвэрлэхдээ тухайн хуралд оролцож байгаа нийт саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшиж буй хувь нийлүүлэгчийн дэмжсэн саналаар асуудлыг шийдвэрлэхээр, үүнээс бусад асуудлыг тухайн хуралд оролцсон нийт саналын эрхийн олонхийг эзэмшиж буй хувь нийлүүлэгчийн дэмжсэн саналаар шийдвэрлэхээр заажээ.

“Оюу толгой” төслийг хэрэгжүүлэгч “Оюу толгой” компанийн хувь нийлүүлэгчийн бүтэц нь гадаадын хөрөнгө оруулагч 66 хувь, Монголын Улсын Засгийн газар 34 хувь эзэмшдэг харьцаатай. Аль ч тохиолдолд Монголын тал хувь нийлүүлэгчийн шийдвэрт нөлөөлөх эрх зүйн боломжгүй байхаар ХНГ-ээр зохицуулжээ. Хувь нийлүүлэгчийн 100 хувийн саналаар шийдвэр гаргах аливаа асуудлыг тусгаагүй байна. Тухайлбал, Монгол Улсын Компанийн тухай хуулийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох” гэсэн 63.5 болон 63.8-д зааснаар тодорхой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар асуудлыг шийдвэрлэх саналын хувийг дийлэнх олонхоос дээгүүр тогтоож болох хуулийн заалттай. Өөрөөр хэлбэл, Компанийн тухай хуулийн 62.1-62.6-д заасан (1) компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, (2) нийлүүлэх нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, (3) компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох, (4) компанийн хэлбэрийг өөрчлөх, (5) компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох, (6) хувьцааг хуваах буюу нэгтгэх) зэрэг асуудлыг Хувь нийлүүлэгчид 100 хувийн саналаар шийдвэрлэдэг байх заалтыг Компанийн дүрэмд оруулах боломжтой. ХНГ байгуулахдаа Монголын тал хуулийн энэхүү боломжийг ашиглаагүй байна.

7. “Эрдэнэс МГЛ” компани ХНГ байгуулахдаа “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн шийдвэр гаргахад нөлөөлөх Компанийн тухай хуулийн зохицуулалтыг ашиглаагүй, гадаадын хамтрагч талд давуу байдал олгосныг Хувь нийлүүлэгчийн хурлын шийдвэр гаргах зохицуулалт хийхдээ мөн давтсан байна. “Оюу толгой” төслийг хэрэгжүүлэх гадаадын хөрөнгө оруулагчтай 2009 болон 2011 онд Хувь нийлүүлэгчийн гэрээ байгуулахдаа Монгол Улсын Компанийн тухай хуулиар Монголын талд боломж олгосон заалтыг ашиглаагүй, “Оюу толгой” компанийн аливаа шийдвэр гаргах эрх бүхий байгууллагууд болох Хувь нийлүүлэгчийн

хурал, ТУЗ-ийн хурал, Менежментийн баг зэрэгт ямар ч эрх эдлэхгүй, гадаадын хамтрагч талд шийдвэр гаргах бүх давуу эрхийг олгосон байна.

8. “Оюу толгой” компанийн ТУЗ нь АйВиЭн, эсхүл ОТН буюу тэдгээрийн нэг буюу түүнээс дээш хамаарал бүхий компанийг дангаар, эсхүл бүлэг болгон хамтад нь Менежментийн баг болгон авч ажиллуулахаар заажээ.

Гэрээнд заалтаас дүгнэхэд Монголын тал Менежментийг багийг сонгох, томилох, өөрчлөхөд оролцоогүй, нөлөөлөл үзүүлэх ямар ч боломжгүй. Менежментийн багийг зөвхөн гадаадын хамтрагч талаас санал болгож, ТУЗ-ийн шийдвэрээр томилно. “Оюу толгой” компанийн ТУЗ шийдвэр гаргахад Монголын талын 3 гишүүний санал нөлөөлөхгүй. Иймд “Оюу толгой” төслийг хэрэгжүүлэгч хамтрагч талууд эрх тэгш бус харилцаатай гэж үзнэ.

9. Менежментийн баг нь Компанийн гүйцэтгэх удирдлагаас тусдаа бүтэц бөгөөд үйл ажиллагаа нь ямар нэгэн хязгаарлалтгүй байна. “Оюу толгой” компанийн гүйцэтгэх удирдлага гэхээсээ энэхүү Менежментийн багт компанийн удирдлага, үйлдвэрлэл, санхүүгийн бодит эрх мэдэл байна.

10. Компанийн гүйцэтгэх удирдлагын дээр Менежментийн баг гэдэг удирдлагын давхар бүтэц оршиж, улирал тутам төлбөр авч байна. “Оюу толгой” компанийн үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийг энэхүү Менежментийн баг дангаараа тогтоож байна. Энэ төлбөрийг манай өмнөөс Айвенхоугийн санхүүжүүлэгчид төлж, Монголын талд хүүтэй зээл болон бичигдэж, өрийн дарамтад оруулж байна.

Менежментийн баг 2009 оноос 2011 оны ХНГ байгуулагдах хүртэл 3 хувийн үйлчилгээний төлбөр авсан бол, түүнээс хойших хугацаанд 6 хувийн төлбөр авч байна. Менежментийн багт төлсөн төлбөрийн хэмжээг “Оюу толгой” компаниас шаардан гаргуулж, бодит үр дүнг шалган тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.

11. Менежментийн баг нэрээр хөрөнгө оруулагч тал “Оюу толгой” компанийг удирдах эрхийг өөртөө авч, мөн менежментийн үйлчилгээ нэрээр төлбөр авах боломжтой болжээ. Менежментийн баг нь гадаадын хамтрагч талын халхавч төдий бүтэц гэж дүгнэж байна. Компанийн гүйцэтгэх удирдлага өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж байхад ийм давхар зардал ихтэй бүтэц шаардлагагүй.

Менежментийн баг өөрийн үүргийг бүхэлд нь болон хэсэгчлэн АйВиЭн-д шилжүүлсэн үү? Эсхүл ОТН-ийн хамаарал бүхий компанид шилжүүлсэн болон тэдгээрээр тусган гүйцэтгүүлж байгаа юу зэрэг мэдээллийг гаргуулж, дүгнэлт хийх шаардлагатай.

12. “Оюу толгой” компанийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр “Шаардсан мөнгөн хөрөнгийн бүх нийлүүлэлтийг америк доллараар хийх”-ээр тохирчээ. “Оюу толгой” төсөлд америк доллараар санхүүжилт хийгдсэнээр долларын ханшны зөрүүгээр Монголын тал их хэмжээний алдагдал хүлээж байна. Ийнхүү 2009 оноос хойш ханшны зөрүүгээр өнөөдрийг хүртэл Монголын талын хүлээсэн алдагдлыг тооцож гаргах шаардлагатай.

13. Гэрээгээр “Оюу толгой” компанид нийлүүлэхээр шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх Айвенхоугийн хувь нийлүүлэгчийн үүргийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгч, эсхүл Айвенхоугийн өөр хувь нийлүүлэгч гүйцэтгэж болохыг Монголын тал зөвшөөрсөн байна.

АйВиЭн-д уг мөнгөн хөрөнгийг нийлүүлэгч нь санхүүжүүлэгч гэх ямар нэгэн санхүүгийн байгууллага, хуулийн этгээд байж болохоор байна. Ингэснээр гадаадын хөрөнгө оруулагч нь бүр эхнээсээ өөрийн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт биш санхүүжүүлэгч байгууллагын хүүтэй зээлээр “Оюу толгой” төслийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ гэж үзэж байна. ХНГ-ээр санхүүжилтийн зээл, түүнийг хүүг төлөх үүргийг хувь нийлүүлэгч хүлээж байгааг өөрчилж, тодорхой болгох нь чухал. Айвенхоу нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр биш санхүүжүүлэгчийн зээлээр “Оюу толгой” компанийг санхүүжүүлсэн тохиолдолд зээл, зээлийн хүүг хамтарсан “Оюу толгой” компани хуулийн этгээдийн хувьд өөрөө хариуцаж, өөрийн үйл ажиллагаанаас төлөх нь бизнесийн зарчимд нийцнэ.

14. Хувь нийлүүлэгчийн гэрээг байгуулахдаа санхүүжилтийг хүүтэй зээлээр хийхээр төлөвлөсөн байна. “Оюу толгой” компанийн 34 хувийг эзэмшиж байгаа Хувь нийлүүлэгч болох “Эрдэнэс МГЛ” компани үүнд хамаарна. Ингэснээр Монголын тал 2009 оны ХНГ хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацаанд (Монголын тал хувь нийлүүлэгч болоогүй байхад зарцуулсан мөнгө) “Оюу толгой” төсөлтэй холбоотой “Айвенхоу групп” болон “Рио Тинто” группээс Компанид урьдчилан олгосон бүх санхүүжилт болон түүний 9.9 хувийн хүүг төлөх үүргийг хуваалцахаар тохиролцжээ.

Тэгээд ч тэрхүү санхүүжилт нь “Оюу толгой” компанийн үйл ажиллагаанд зарцуулсан эсэхээс үл хамаарч байхыг зөвшөөрсөн нь шударга бус зохицуулалт бөгөөд энэ заалтын дагуу компанийн үйл ажиллагаанд зарцуулаагүй мөнгө хөрөнгийг зөвшөөрөхгүй байх нь зүйтэй. Иймд 2009 оны ХНГ-г байгуулахаас өмнө “Оюу толгой” төсөлд зарцуулсан гэх мөнгөн дүн, хүүгийн хамт хэд болсон болох, энэ мөнгөн дүнгийн хэдэн хувь нь Монголын талын төлөх өр болсон эсэхийг дахин эргэж нягтлан шалгах нь зүйтэй байна.

15. “Оюу толгой” төслийг санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийг АйВиЭн компани бүр эхнээсээ өөрийн санхүүжүүлэгчээс зээл хэлбэрээр авахаар төлөвлөжээ гэдгийг дахин онцлон тэмдэглэж байна. Санхүүжилтийн хэлбэрийг сонгох эрхийг Айвенхоугийн хувь нийлүүлэгчид гэрээгээр зөвшөөрчээ. Нэгэнт санхүүжилтийн хугацаанд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр, өөрийн тодорхойлсон хэлбэрээр нийлүүлэхээр гэрээнд заасан байхад ХНГ-ний 8.2-т заасан “Хувь нийлүүлэгчийн өрийн хэлбэр”-ийг Айвенхоугийн хувь нийлүүлэгчид тодорхойлох нь ойлгомжтой байна.

“Оюу толгой” төсөлд гадаадын хамтрагч тал шууд хөрөнгө оруулалт хийхгүй, зээлийн санхүүжилт хийх боломж олгосон заалт оруулж, түүнийг баталгаажуулах хэлбэрээр ХНГ-г байгуулсан байна.

16. “Оюу толгой” төслийн санхүүжилтийг 2009 оны ХНГ байгуулагдаж, хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн хугацаанд Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй “АйВиЭн” компанийн санхүүжүүлэгч бүрэн хэмжээгээр зээлээр хийхээр болжээ.

“Оюу толгой” төслийн санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгийг гаргасан Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй “АйВиЭн” компанийн санхүүжүүлэгч хэн болох, түүний санхүүжилтийн мөнгө дүн, санхүүжилтийн нөхцөлийн тухай мэдээллийг ил тод болгох шаардлагатай байна.

“Оюу толгой” төслийг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамжийг баталсан УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолд “Ордыг түшиглэн байгуулагдах компанийн хувьцааны 34 хувийг Монголын тал шууд эзэмшихээр тооцож, бүтээгдэхүүн хуваах зарчимд тулгуурласан хувилбар, уг хувьцаанд ногдох хөрөнгийг албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, зээл зэрэг хэлбэрээр оруулж болохоор тохиролцох” гэж заасан. УИХ-аас тогтоосон дээрх аргуудаас зөвхөн “зээл” хэлбэрийг дангаар сонгосон нь өрийн дарамт үүсгэсэн оновчгүй тохиролцоо болжээ гэж дүгнэж байна.

17. 2011 оны ХНГ-ээр Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь санхүүжилтийг бүрэн хэмжээгээр өөрийн сонгосон хэлбэрээр хийж байна. Гэхдээ үүнийг заавал хэрэгжүүлэх үүрэг болголгүй, өөртөө давуу байдал авч үлдсэн байна. Аль ч тохиолдолд санхүүжилтийн хугацаанд ч тэр, санхүүжилтийн дараах үед тэр “Оюу толгой” төслийн санхүүжилтийн хөрөнгийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгч, эсхүл Айвенхоугийн хувь нийлүүлэгчид өөрийн үзэмжээр шийдвэрлэж, түүнийг нь “Эрдэнэс МГЛ” болон “Оюу толгой” компани хүлээн зөвшөөрнө гэдгийг тохирчээ.

“Оюу толгой” компанийн удирдах байгууллагуудын болон төслийн санхүүжилттэй холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд Монголын тал ямар ч нөлөөгүй байна. Хөрөнгө оруулагч тал өөртөө Компанийн удирдлага, үйлдвэрлэл, санхүүжилтийн үйл ажиллагаа зэрэг бүхий л үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг өөрийн үзэмжээр бие даан гаргахаар 2009 оны болон 2011 оны ХНГ-нд тусгажээ.

18. 2009 оны ХНГ-д заахдаа Айвенхоугийн хувь нийлүүлэгчид санхүүжилтийн эрхийг бүрэн өөртөө авч байсан бол 2011 оны нэмэлт, өөрчлөлтөөр энэ эрхээ хэрэгжүүлж болох хувилбараас гадна эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаад ТУЗ-ийн хурлаар санхүүжилтийн бусад арга хэлбэрийг тодорхойлох хувилбарыг оруулсан байна.

Айвенхоугийн гишүүд ТУЗ-ийн дийлэнх олонхийг бүрдүүлж, дангаараа шийдвэр гаргах эрхийг хадгалж байгаа учир ТУЗ-ийн шийдвэр нь Айвенхоугийн хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хангасан хэлбэрээр гарах нь тодорхой учир энэ нь Монголын талд ашигтай байдал үүсгэхгүй.

19. 2009 болон 2011 оны ХНГ-нд шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд түүний эзэмшлийн хувь хэмжээ (төрийн эзэмшлийн хувьцааг гарган ТӨК-д шилжүүлсний дараах 34 хувь)-г бууруулж болохгүй” гэж тодотгож заасан нь Монголын талын эзэмших хувьцааны хувь хэмжээ буурахгүй байх эрх ашгийг хангаж байгаа хэдий ч энэ нь мөнгөн хөрөнгө гаргахгүй гэсэн үг биш юм.

2009 оны ХНГ-ээр “Хувь нийлүүлэгчид нь шаардсан мөнгөн хөрөнгө бүрт өөрийн эзэмшлийн хувь хэмжээний дагуу хөрөнгө нийлүүлнэ” гэж үүрэг хүлээж, АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь Монголын талын өмнөөс төлөхөөр заажээ. Энэхүү санхүүжилттэй холбоотой Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь санхүүжилтийг хийхдээ энгийн хувьцаа гаргах аргыг тодорхойлсон бол “Эрдэнэс” МГЛ нь 3 жилийн хугацаанд шаардсан мөнгөн хөрөнгийг хийх эрхээ эдлэхгүй, харин 3 жил өнгөрсний дараа шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд буюу хэсэгчлэн нийлүүлж болно (гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй) гэжээ. Монголын

талын эрхийг 3 жилээр хязгаарласан энэ заалт нь АйВиЭн-ийн санхүүжүүлэгч Монголын талын өмнөөс төлбөр төлөх заалтаар тайлбарлагдаж байна.

Хөрөнгө оруулагч тал Монголын талын хувь нийлүүлэгчийг аль болох өөрөөсөө санхүүгийн хувьд хараат, өртэй байлгах бодлого эхнээсээ явуулжээ үзнэ. Өөрөөр хэлбэл, төслийн санхүүжилтийг бүх хэлбэрийг Айвенхоугийн хувь нийлүүлэгч өөрөө сонгох, санхүүжүүлэгчээс зээл хэлбэрээр авч байх, Монголын талын хувь нийлүүлэгч нь зөвхөн энэ эх үүсвэрээс санхүүжилт авч өр үүсч байхаар зохион байгуулсан байна.

20. Монголын тал бие даан санхүүжилт хийх эх үүсвэр олсон ч Айвенхоугийн тавьсан нөхцөлүүд бүгд хангагдсан тохиолдолд хэрэгжинэ гэсэн хязгаарлалт тогтоосон. Өөрөөр хэлбэл, Айвенхоугийн хувь нийлүүлэгчийн тавьсан нөхцөл хангагдаагүй тохиолдолд Монголын тал өөрийн олсон эх үүсвэрээр мөнгөн санхүүжилт хийх боломжгүй байхаар гэрээнд тусгасан.

Гэтэл гадаадын хөрөнгө оруулагч талын санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийн нөхцөлд Монголын талаас ямар ч нөхцөл заагаагүй байна. Иймд энэхүү гэрээг харилцан ашиггүй, гэрээний эрх тэгш байдлыг хангаагүй гэж үзнэ.

2009 оны ХНГ-ний 10.1 (ж) заалт 2011 онд арай уян хатан хэлбэртэй болж өөрчлөгдсөн байна. Тухайлбал, "...Шаардсан мөнгөн хөрөнгийг энэхүү гэрээний 11, 13-т заасны дагуу ТӨК өөрөө нийлүүлэх эрхтэй бөгөөд ТӨК-ийн сонгосон санхүүжилтийн арга хэлбэрийн нөхцөл, болзол нь тухайн үеийн болон ирээдүйд авахаар төлөвлөж буй төслийн аливаа санхүүжилттэй зөрчилдөхгүй, эсхүл саад болохгүй байхын зэрэгцээ АйВиЭн-ийн Компанид хийсэн санхүүжилтийн нөхцөл, болзлоос дутуугүй байна" өөрчлөн найруулжээ. Хэдийгээр "Эрдэнэс МГЛ" ийм эрхтэй ч энэ заалтад байгаа нөхцөлүүдийг биелүүлэх боломж хязгаарлагдмал юм.

21. Монголын талын хувь нийлүүлэгчийн өмнөөс төлж байгаа АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн санхүүжүүлсэн бүх дүнд хүү төлнө. Өөрөөр хэлбэл, Монгол Улс өөрийн эзэмшлийн 34 хувийг болон "Оюу толгой" компанийн үйл ажиллагааны санхүүжилтийн өөрт ногдох хэсэгт өр үүсгэн өөртөө үүрэг хүлээж байна.

ХНГ-нд энэхүү үлдэгдэл төлбөрийг "Эрдэнэс" МГЛ-д ногдох ногдол ашгаас төлж барагдуулахаар заажээ. Өөрөөр хэлбэл, энэ төлбөрийг өөр бусад эх үүсвэрээс төлөхийг хориглосон заалт болжээ гэж дүгнэж байна. Ийм заалт гэрээнд оруулсан нь Монголын талыг өрийн дарамтад байлгах гадаадын хамтрагчийн зорилгыг дахин баталж байна.

Эдгээр заалтуудаас анхаарал татаж байгаа нь 11.4 (б)-д заасан "ТӨК нь ... үлдэгдэл төлбөрийн эргүүлж төлж дуусах хүртэл өөрт ногдох ногдол ашгийг бүхэлд нь АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн хувь нийлүүлэгчээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) шууд төлөхийг Компанид энэхүү гэрээгээр эргэлт буцалтгүйгээр чиглэл болгож байна" гэсэн заалт, ХНГ-ний 15.2 (б) "Компани нь энэхүү гэрээний 15.2 (а) (i)-д заасны дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид үлдэгдэл төлбөр төлөх нь ТӨК-д ногдол ашиг төлөх үүргээ биелүүлж байгаатай ижил гэж тооцогдоно" гэсэн заалт, мөн гэрээний 15.2 (в) "Талууд өөрөөр тохироогүй бол ...ТӨК нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай

хуулийн 21.8-д заасан өөрт ногдох ногдол ашгаа дайчлах эрхээ эдлэхгүй” гэсэн заалтууд байна. Дээр дурдсан заалтуудаар Монголын тал ирээдүйд авах ногдол ашгаа өр төлөхөд зориулахаар байна.

Гэрээний үндсэн хугацаа 30 жил, хоёр удаа тус бүр 20 жилээр сунгах 40 жил, нийт 70 жилийн санхүүжилтийн дүнгээс Монголын талын 34 хувьд хувь тэнцүүлэн тооцож, өр болох үнийн дүнг тооцож гаргах шаардлагатай. Ирээдүйд үүсэх энэ өрийг Монголын тал ногдол ашгаас төлөөд цаана нь ашиг үлдэх үү гэдэг нь энэ ордыг ашиглах ач холбогдлыг тодорхойлно.

2009 оны ХНГ-ний 11.1-д зааснаар Компанийг санхүүжүүлэх нэг арга нь санхүүжүүлэх хувьцаа гаргах арга ажээ. 2009 оны ХНГ-ийн 11.1 (а)-д зааснаар энэ аргаар санхүүжилт хийхэд “Эрдэнэс МГЛ” оролцохгүй, тийм үүрэг хүлээгүй бөгөөд зөвхөн АйВиЭн, ОНН, эсхүл тэдгээрийн томилсон этгээд болох “Рио Тинто групп”, “Айвенхоу групп”-ийн аливаа гишүүн хамаарахаар заажээ. Энэ нь хэдийгээр ТӨК-д мөнгө хөрөнгө гаргахгүй байх давуу байдал олгож байгаа мэт харагдавч гадаадын хамтрагч талд л ашигтай болжээ. Учир нь ХНГ-ийн 11.3 (а)-д зааснаар санхүүжүүлэх хувьцаанд улирал тутам ногдол ашиг төлж байна. Гадаадын хамтрагч тал санхүүжүүлэх хугацаанд ногдол ашиг хэдийг авсныг тооцох нь зүйтэй.

22. 2009 оны ХНГ-ний 12 дугаар зүйлд АйБиЭн-ийн санхүүжүүлэгчээс өрийн санхүүжилт хийхээр зохицуулжээ. Энэ зүйлд зааснаар санхүүжилтийн хугацаанд (буюу энэ гэрээ хүчин төгөлдөр болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 жилийн хугацааны санхүүжилтийг хангахад) санхүүжилтийг Хувь нийлүүлэгчдээс олгох өрийн хэлбэрээр нийлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлнэ гэжээ. Энэ санхүүжилт нь улирал тутам төлөх хүүтэй байна.

Дээрх заалтаас харахад санхүүжилтийг хийх шийдвэрийг Айвенхоугийн хувь нийлүүлэгчид дангаараа бие даан гаргана. Санхүүжилттэй холбоотой бүхий л шийдвэрийг гарах, хэнээс санхүүжилт авах зэрэг асуудлыг зөвхөн өөрт хамааралтай этгээдүүдтэй холбож ХНГ-нд олон удаа, байнга давтан зааж баталгаажуулжээ. Энэ заалтыг 2011 оны ХНГ-ээр Хувь нийлүүлэгчийн зээл болгон өөрчилж зохицуулжээ.

23. “Эрдэнэс МГЛ” компани “Оюу толгой” төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргах боломж гэрээнд байгаа хэдий ч энэ боломжийг Монголын тал ашиглахад хүндрэлтэй. Энэ эрхийн дагуу “Эрдэнэс МГЛ”-ээс хийх санхүүжилт нь “АйВиЭн-ийн Компанид хийсэн санхүүжилтийн нөхцөл, болзлоос дутахгүй байна” гэсэн шаардлагыг хангаж чадах эсэх нь эргэлзээтэй. Гэрээнд зааснаар АйВиЭн-ийн санхүүжүүлэгч зээлээр санхүүжүүлж байна.
24. Компанид буюу “Оюу толгой” компанид шаардлагатай шаардсан мөнгөн хөрөнгийг олж нийлүүлэх зохицуулалт хийхдээ үндсэн хоёр хэсэгт хуваажээ. Нэгдүгээрт, санхүүжилтийн хугацаанд (энэ гэрээ хүчин төгөлдөр болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 жил өнгөрөх хүртэлх хугацаа) хоёрдугаарт, санхүүжилтийн хугацааны дараах үе (санхүүжилтийн хугацааны 3 жил дууссаны дараагаас төсөл дуусах хүртэлх хугацаа). Энэ бүх хугацааны санхүүжилтийг (1) энгийн хувьцаа гаргах, (2) санхүүжүүлэх хувьцаа гаргах, (3) өрийн санхүүжилт хийх, (4) олон улсын санхүүгийн байгууллагаас санхүүжүүлэх гэсэн аргуудыг хэрэглэхээр заажээ.

Санхүүжилтийн 4 дүгээрт заасан аргаас бусад тохиолдолд санхүүжилтийг Айвенохоугийн хувь нийлүүлэгчид болон “Рио Тинто групп” түүний хамааралтай этгээдүүд бие дааж, өөрийн үзэмжээр удирдах эрхийг гэрээгээр баталгаажуулжээ. Бүх санхүүжилт нь Компанид өр үүсгэж байгаа бөгөөд улирал бүр хүү төлж байна.

“Оюу толгой” төслийн санхүүжилтийн хувьд Монголын тал гадаадын хамтрагч талаас санхүүгийн бүрэн хараат байдалд орж, санхүүгийн хувьд ямар нэгэн байдлаар Монголын тал бие даасан үйл ажиллагаа явуулах боломжгүйгээр зохицуулалт хийжээ.

25. Монголын тал төслийн санхүүжилтэд үүрэг хүлээхгүй хэмээн заасан нь давуу байдал мэт харагдаж байгаа хэдий ч төслийн санхүүгийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байхаар зохицуулж, санхүүжилтийн төлбөрт Монголын талын нэр дээр өр бичигдэж, улирал бүр зээлийн хүү төлж, өрийн дарамтад орж байна. Санхүүжилтийн дүнгээс төлөөгүй үлдсэн буюу хуримтлагдсан үлдэгдэл төлбөрийг ирээдүйд өөрт ногдох ногдол ашгаас төлнө.

Санхүүжилттэй холбоотой аливаа шийдвэрийн Айвенохоугийн хувь нийлүүлэгч, АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид гаргаж, Монголын тал түүнийг нь заавал дэмжих үүрэг хүлээсэн байна. 2009 оны ХНГ-ний энэхүү зохицуулалтын дагуу компанийн үйл ажиллагаа явсан тул хийсэн ажлыг нь шалган Монголын талын эрх ашиг сонирхолд учирсан эерэг, сөрөг талыг тооцон үзэх нь зүйтэй.

26. 2009 оны ХНГ нь үүргээ нэгэнт гүйцэтгэсэн учир 2011 онд уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан гэж дүгнэж байна. 2009 оноос хойш санхүүжилтийн хугацааны 3 жил өнгөрч, цаашид энэ аргыг гадаадын хөрөнгө оруулагч хэрэглэхгүй болсон учир өөрчилсөн гэж үзэж байна. Тиймээс 2009 оны ХНГ-ээр 2011 он хүртэл санхүүжилт хаанаас авсан болох, түүний үр өгөөжийг сайтар судалж үзэх шаардлагатай.

27. Дэлхийн алт зэсийн том орд болох Оюу толгойн ордыг ашиглах талаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хамтран ажиллах гол сонирхол, нөхцөл нь уг ордын баялгаас ашиг хүртэх явдал юм. Энэ зорилгоор ногдол ашиг авахтай холбоотой заалт нь гэрээний хамгийн гол зүйл, Монголын талын ашиг сонирхол юм.

Ногдол ашигтай холбоотой заалтыг 2009 оны ХНГ-ний 14 дүгээр зүйлд тусгасан. Гэрээнд ногдол ашиг хуваарилахтай холбоотой 2 зүйл, 7 хэсэг, 7 заалт байна. Тэдгээрт заахдаа Компани нь тухайн жилд ашигтай ажилласан бол ТУЗ нь ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргана, ингэхдээ Компанид 5 үүрэг хүлээлгэж, тэдгээрийг дэс дараалан биелүүлээгүй тохиолдолд ногдол ашиг хуваарилахгүй ажээ. Эдгээр нь өмнө авсан бүх төрлийн санхүүжилт, өр, зээл, түүний хүү, давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашгийг төлсөн байх нөхцөлүүд байна. Эдгээр төлбөрийг төлөөд Компанид үлдэх ашиг байх уу гэдэг нь Монголын талын анхаарах асуудал юм.

2009 оны ХНГ-ийн 14.2 (б)-д “Компани энэхүү гэрээний 14 (а), (i)-д заасны дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид үлдэгдэл төлбөр төлөх нь ТӨК-д ногдол ашиг төлөх үүргээ биелүүлж байгаатай ижилд тооцогдоно” гэж зааж, өрийн төлбөрийг ногдол ашигт тооцно хэмээн төөрөгдөл үүсгэж байна. Ингэснээр төслөөс Монголын тал ногдол ашиг авсан мэтээр тохиролцоо хийжээ. ХНГ-ийн 14.2 (в) заалтаар “...ТӨК нь аж ахуйн орлогын албан татварын тухай хуулийн 21.8-д

заасан өөрт ногдох ногдол ашгаа дайчлах эрхээ хэрэгжүүлэхгүй” гэсэн үүрэг авсан нь хууль бус гэж үзэж байна. Хууль хэрэгжүүлэхгүй байх үүргийг гэрээгээр хүлээж болохгүй. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж, хангах” үүрэг хүлээсэн Засгийн газар, гадаад улсын компанийн өмнө хууль хэрэгжүүлэхгүй байх үүрэг хүлээсэн нь хууль зөрчсөн үйлдэл юм.

2009 оны ХНГ-ний эдгээр заалтууд 2011 оны ХНГ-ний 15.2 болон хэвээр үлдсэн.

Монголын талаас үл хамаарч шийдвэр гаргах эрхтэй болохын хувьд гадаадын хамтрагч, хувь нийлүүлэгч талын хамааралтай санхүүжүүлэгч нарын авсан хүүтэй зээлийн санхүүжилт, бусад төлбөрийг төлж дуусахад Компани өртэй үлдэх зориуд, санаатай зохион байгуулсан санхүүгийн схем бүтэц зохиожээ гэсэн хардлага төрүүлж байна.

28. Монгол Улс өөрийн эзэмшлийн хувьцааны 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр худалдах асуудалд хязгаарлалт тогтоогоогүй. Монгол Улсын Засгийн газар өнөөдрийг хүртэл энэхүү боломжоо ашиглаагүй байна.
29. 2011 оны ХНГ-ийн 16.4-д хувь нийлүүлэгч өөрийн эзэмшлийн хувьцааг барьцаалах тухай зохицуулсан байх боловч ХНГ-ийн 16.5-д заасан шаардлагуудыг хангаж байж энэ эрхээ хэрэгжүүлэх боломжтой. Гэвч Монголын тал энэ шаардлагыг хангах боломжгүй. Тухайлбал, ХНГ-ийн 16.5 (б) хэсгийн (iii) заалтын В)-ийн 2 “ТӨК-д төлөх ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон АйВиЭн-ийн санхүүжүүлэгч авсны дараа нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрөв” гэсэн болон ХНГ-ийн 16.5 (в) хэсгийн (iii)-т тус тус заасан “ТӨК-д төлөх ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон Айвенхоугийн санхүүжүүлэгч тэргүүн ээлжид авах эрхээ эдэлсний дараа зөвшөөрөгдсөн барьцаалагчийн эрх нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрөв” гэсэн шаардлага хангагдах нь бэрхшээлтэй.
30. 2011 оны ХНГ-ний 16.5 (а) заалтыг ашиглан Монголын тал өөрийн эзэмшлийн 34 хувийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагад барьцаалан зээл авах боломж байгаа мэт боловч ийнхүү зээл авах асуудлыг ТУЗ шийдвэрлэж байгаа нь хүндрэл учруулна. Монголын тал ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлөх саналын эрхгүй. Энэ эрхийг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар болон “Эрдэнэс МГЛ” ямар нэгэн үйл ажиллагаа өнөөдрийг хүртэл хийгээгүй байна.
31. 2009 оны болон нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон 2011 оны ХНГ-ээс харахад “Оюу толгой” төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой Монголын талд үүрэг хүлээлгэсэн, эрхийг нь хязгаарласан, аливаа эрхээ хэрэгжүүлэхэд нь биелэгдэх боломжгүй нөхцөл, болзол тавьсан заалт олон байна. Цөөн хэдэн боломж байгаагийн нэг нь ХНГ-ийн 16.6-д зааснаар төр нь өөрийн эзэмшлийн хувьцаагаа Монголын хөрөнгийн бирж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийг биржид арилжих эрхтэй.
32. “Оюу толгой” компанийн Монголын талын 34 хувийн эзэмшил 100 хувь төрийн өмчид байх нь гадаадын хөрөнгө оруулагчийн санхүүжилтийн болзол болж байна. Иймээс дэлхийд нөлөө бүхий их гүрний үндэстэн дамнасан хөрөнгө оруулагчийн Монгол Улсын улс төрд нөлөөлж, лобби хийх гол объект нь Засгийн газар болжээ.

Үндэстэн дамнасан “Рио тинто” гэх хүчирхэг нөлөөтэй гадаадын хамтрагч өөрийн бизнесийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурал болон Засгийн газарт нөлөөлөх лобби бүтэц бий болгож, Монголын улс төрд нөлөөлж байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, “Рио тинто” хэмээх улс биш үндэстэн дамнасан компани Монгол Улсын улс төр, эдийн засгийн нөлөө бүхий хамтрагч болж өөрийн бодлогыг УИХ, Засгийн газрын хэмжээнд явуулж, улс төрийн эрсдэл үүсгэж байна.

33. 2009 оны ХНГ-ний 15.10 болон 2011 оны ХНГ-ний 16.10-д Монголын тал Компани дахь хувь эзэмшлээ 16 хувиар нэмэгдүүлж, 50 хувь болохтой холбоотой зохицуулалтыг тусгажээ. Гэхдээ Хөрөнгө оруулалтын гэрээг анх удаа сунгасан өдрөөс хойш 1 жилийн дотор хувь хэмжээгээ нэмэгдүүлэх эрхтэй гэдэг нөхцөл заажээ. Энэ нөхцөлөөр Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн хугацаа 30 жил дээр анх удаагийн сунгалтын 20 жилийг нэмж, нийт 50 жилийн дараа буюу 2059 онд Монголын талд энэ дээрх эрх нь үүснэ.

Ингэхдээ “Эрдэнэс МГЛ” болон Айвенхоугийн хувь нийлүүлэгчид харилцан зөвшөөрсөн нөхцөлөөр хэрэгжүүлнэ” гэж ХНГ-нд заажээ. Харилцан зөвшөөрсөн нөхцөл нь ямар байх тухай гэрээнд огт заагаагүй учир Айвенхоугийн хувь нийлүүлэгчид хүлээн авах боломжгүй аливаа нөхцөл тавих замаар харилцан зөвшөөрөхгүй байхад энэ эрх хэрэгжихгүй.

Тэгээд ч энэ тохиролцоо нь УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Оюу толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамж”-ийн 2 дахь хэсгийн 1-д заасан “Монголын талын эзэмшлийг 34 хувиас эхэлж, анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа 50 хувь болгох асуудлыг гэрээнд тусгах хувилбар” гэж заасныг зөрчсөн байна.

34. 2011 оны гэрээний 16.10 (г)-д зааснаар Монголын тал 50 хувь болсон ч “Оюу толгой” төслийг удирдах эрх мэдэл нэмэгдэхгүй, харин ч Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь “Оюу толгой” төслийн менежментийн эрхийг бүрэн хэмжээгээр, хязгаарлалтгүйгээр эдэлж байна.

Монголын тал 50 хувийн хувьцаа эзэмшсэн ч хувь нийлүүлэгчийн болон ТУЗ-ийн бүх хуралд Айвенхоугийн хувь нийлүүлэгч шийдвэрлэх саналын эрхтэй байна гэжээ. Үүнээс харахад 2059 онд Монголын тал хувьцааны 50 хувийг эзэмших болсон ч шийдвэр гаргах эрх болон “Оюу толгой” компанийн санхүү, менежмент, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдах эрх шилжихгүй, 34 хувьтай байх үеэс өөрчлөгдөхгүй. Харин ч Айвенхоугийн хувь нийлүүлэгчид нь “Оюу толгой” төслийн менежментийн эрхийг бүрэн хэмжээгээр, аливаа хязгаарлалтгүйгээр эдлэхийг баталгаажуулж, Хувь нийлүүлэгчийн гэрээ болон компанийн бусад баримт бичигт шаардлагатай өөрчлөлтийг хийхээр тохирчээ.

35. Хувь нийлүүлэгчийн гэрээний үйлчлэл, түүнийг дагаж мөрдөх зохицуулалтыг 2009 оны ХНГ-ний 18-д, 2011 оны ХНГ-ний 19-д заасан бөгөөд энэхүү гэрээ нь Компанийн дүрмийн заалттай зөрчилдвөл гэрээний заалтыг баримтлах давуу эрхтэй байна. Иймд компанийн дүрмээр хувь нийлүүлэгч болон ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд тусгайлан эрх олгосон ямар нэгэн заалт тусгасан ч ХНГ-тэй зөрчилдвөл түүнийг дагаж мөрдөхгүй байхаар зохицуулжээ.

Монгол Улсын Компанийн тухай хуульд зааснаар компанийн дүрэмд өөрөөр зааж болох зохицуулалтыг зөвшөөрсөн байдаг. Хувь нийлүүлэгчийн гэрээнд өөрөөр

заасан нь дүрмээс давуу үйлчлэх тухай зохицуулалт Компанийн тухай хуульд байхгүй.

36. 2009 оны болон 2011 оны ХНГ-д “Хувь нийлүүлэгч болон түүний хамаарал бүхий компани (аль холбогдох нь) авлигатай тэмцэх талаарх өөрийн үүсгэн байгуулагдсан улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх бөгөөд Монгол Улсад явуулах үйл ажиллагаагаа эдгээр хуулийн хүрээнд явуулна” гэж заасан нь авлигаас ангид байх чухал заалт болжээ.

Манай улсын хууль хяналтын байгууллагууд ялангуяа, АТГ энэ заалтын дагуу үйл ажиллагаа явуулах боломжтой.

ГУРАВ. САНАЛ.

Оюу толгойн ордыг ашиглах Хувь нийлүүлэгчийн гэрээнд гарын үсэг зурах зөвшөөрлийг УИХ олгоогүй, энэхүү гэрээг УИХ-д танилцуулаагүй.

Оюу толгойн ордыг ашиглахаар гадаадын хамтрагч талтай байгуулсан үндсэн тохиролцоо болох Хувь нийлүүлэгчийн гэрээг Монгол Улсад ашигтай болгож өөрчилж, тэрхүү өөрчлөлтийг үндэслэн Хөрөнгө оруулалтын гэрээг өөрчлөх нь “Оюу толгой” төслийг Монгол Улсад ашигтай байлгах гол гарц болно.

Энэхүү ХНГ-г байгуулсан оролцогч талууд нь Компаниуд учир (Монголын талаас Эрдэнэс МГЛ) гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар хэлэлцээр хийхэд ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарахгүй.

Иймд **Нэгдүгээрт**, Санал, дүгнэлтэд тусгасан гэрээний заалт бүрийг Монгол Улсад ашигтай байхаар Талуудын хооронд байгуулсан Хувь нийлүүлэгчийн гэрээнд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах замаар засах, **Хоёрдугаарт**, Хувь нийлүүлэгчийн гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг үндэслэн Хөрөнгө оруулалтын гэрээг өөрчлөх, **Гуравдугаарт**, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөг (“Дубайн гэрээ” гэх) бүхэлд нь хүчингүй болгож, холбогдох зохицуулалтыг харилцан тохиролцсон хэлбэрээр Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгах, **Дөрөвдүгээрт**, “Оюу толгой” компанийн дүрмийг дээрх гэрээнүүдийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн батлах саналтай байна.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА